



# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.02.22, БААСАН ~ №033 (1085)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

## “ЖДҮ”-чин гишүүд шинэ дуулианыг сэвж буйн шалтгаан

ЖДҮХС-гийн хэрэгт шинэ шуугианаар хуучин дуулианыг дарах технологи ашиглана.

>3

## Бөхийн хоёр өөр төрлөөр дэлхийд амжилт гаргасан хүн Х.Баянмөнх бид хоёр л байдаг юм

>5

## Зээлийн хүүг хүчээр тогтоох нь иргэдийг мөнгө хүүлэл рүү түлхэнэ

Аль ч улс зээлийн хүүг хязгаарлахдаа туйлын болгоомжтой ханддаг.

>11

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE

>7

### ОНЦЛОХ

#### УЛС ТӨР

**БЗД-ийн ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох сонгууль** ирэх сарын 23-нд болно.

**У.Хүрэлсүх: Засаг дарга нарыг ядуурал хэрхэн бууруулснаар нь дүгнэнэ.**

#### ЭДИЙН ЗАСАГ

**“Ремикон” компанийн борлуулалтын орлого** 2018 онд 9.1 тэрбум төгрөгтэй тэнцжээ.

**Glencore нүүрсний олборлолтоо жилийн 145 сая тонноор хязгаарлав.**

#### НИЙГЭМ

**“E-Police аппликейшнээр** ирүүлсэн 90 зөрчилд хариуцлага тооцжээ.

**Зуун айлд төлөвлөлт хийх** хөрөнгө оруулагчдад олон бэрхшээл тулгарчээ.

#### ДЭЛХИЙ

**Австрали автомашины улсын дугаарт** эможи оролцуулахыг албан ёсоор зөвшөөрөв.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

# 2019 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ

## ЭРСДЭЛ: ВАЛЮТЫН ХАНШ



Олон улсын эдийн засаг, геополитикийн тааварлашгүй байдал ханшийн эрсдэл бий болгосор буй. Ийм үед алт тушаалт буурах төлөвтэй байгаа нь эрсдэлийг улам нэмэгдүүлнэ. ► 12

C.Батсайхан / ЗГМӨ

## Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын нийт гишүүдэд

Та бүхэн сайхан хаваржиж байна уу?

2019 оны 2 сарын 28-нд болох Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын сонгуульд миний бие нэр дэвшинхээр болж, та болон танай байгууллагын нийт гишүүдээс дэмжлэг хүсэн ийнхүү хандаж байгааг хүлээн авна уу.

Сүүлийн хэдэн жилийн туршид Монгол Улсад бизнес эрхлэх орчин тогтмол уруудан муудаж, гадаадын хөрөнгө оруулалтыг үргээн хоох, баялаг бүтээгчдийг нийтээрээ гадуурхан жигших, нэр хоч зүүлгэх, донгож бүрэлдэн бий болж байгаа чинээлэг буюу дунд орлоготой нийгмийн давхаргыг үгүй хийх ил далд оролдогууд улам гаарч, понулизмд нэвт идэгдсэн улс төрийн тогтворгүй нөхцөл байдал давамгайлж, улс орны эдийн засгийн тусгаар тогтнол алдагдах, бизнес эрхлэгчдийн эрх чөлөө хумигдах эрсдэл бий болоод байна гэж харж байна.

Бизнесийн нийтлэг эрх ашгийг төлөөлөн илэрхийлж, баялаг бүтээгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үндсэн үүрэгтэй хамгийн том төлөөллийн байгууллага болох МҮХАҮТ-ын манлайллыг идэвхжүүлж, зохион байгуулалтын оновчтой болгон үйл ажиллагааг нь ил тод нээлттэй явуулж, илүү жинтэй, далайцтай хөдөлгөө, бодитой үр дүн гаргаж ажиллах боломж бий гэдэгт би огт эргэлзэхгүй байна. Өнөөдөр Монголын баялаг бүтээгчид бид салбар харгалзалгүй Танхимынхаа манлайлал дор нэгдэж эх орныхоо ирээдүйг зөв зүгт чиглүүлэх, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үр хүүрдийнхээ амьдрах орчныг сайжруулах үйлсэд чин сэтгэлээ зориулан дуу хоолойгоо нэгтгэж төр засагт цаг алдалгүй хүргэх цаг хэдийнээ болжээ.

Иймд, миний бие танаас болон таны удирдаж байгаа байгууллагаас МҮХАҮТ-ын энэ удаагийн сонгуульд дэвшүүлсэн зорилго, мөрийн хөтөлбөртэй минь танилцаж, намайг болон манай багийг дэмжиж өгнө үү гэж хүсч байна.

Хоёрдугаарт, дэвшүүлсэн зорилго, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж, ажил хэрэг болгоход та бүхэнтэй нягт хамтран ажиллах зайлшгүй шаардлага байгаа учраас МҮХАҮТ болон таны салбарын холбоо хооронд үр дүнтэй хамтын ажиллагааны механизмыг бий болгох чиглэлээр санал солилцон шаардлагатай өөрчлөлтүүдийг холбогдох дүрэм, журмандаа оруулах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг санаачлан уриалж байгааг минь хүлээн авна уу.

Гуравдугаарт, МҮХАҮТ-аас болон Танхимын даргын зүгээс нийгэмд, таны манлайлж буй эдийн засгийн салбарт, таны бизнест бүсдэн олж хараагүй ямар асуудал тулгараад байгаа, хэрхэн ажиллавал тэдгээрийг даван туулж болох талаар та өөрийн саналаа идэвхтэй илэрхийлж, хамтран ажиллахыг хүсье. Таны санал болгодог эрх зүйлсийг хэн удирдахаас үл хамааран цаашдын ажилд нь тус болно гэдэгт би бүрэн итгэлтэй байна.

Таны итгэл надад чухал. Таны оролцоо Монгол Улс оронд чухал юм. Тиймээс би тэр итгэлийг олж авч, хариуцлагыг үүрэхийн тулд хэд хэдэн зүйл дээр эргэцүүлэн бодож байгаад шийдвэр гаргаснаа танилцуулахыг хүсч байна.

Нэгт, миний зүгээс өөрийн итгэл үнэмшилдээ хөтөлсөн энэ хариуцлагатай албан тушаалд нэрээ дэвшүүлж байгаа тул цалин хөлс авахгүй ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Би Монголын Эдийн Засгийн Форумыг санаачлан зохион байгуулж, CEO Club-ыг удирдаж, Улаанбаатар хотын Худалдааны Танхимыг үүсгэн байгуулалцаж байхдаа ачааны хүндийг үүрэхээс зайлсхийж байгаагүй ээ. Иргэний нийгмийн олон байгууллагын удирдлагад ажиллахдаа өөртөө авахыг биш, бусдад өгч, бусдадтай хуваацгааж илүүд үзэж ирсэн зарчимтай.

Хоёрт, Танхимын дарга нь улстөрөөс хараат бус байдлаар ажиллах ёстой гэж үзэж буй тул миний бие дээрх хариуцлагатай ажилд та бүхний итгэлийг хүлээж очих тохиолдолд МАН-ын болон МАН-ын Бага Хурлын гишүүнчлэлээс тугдгээх болно. Ингэснээр баялаг бүтээгчдийн дуу хоолой ямарнаа татлаагүй, улстөрийн нөлөөгүй, хүлээхгүй болно гэж харж байна. Нийт Монголын бизнес эрхлэгчдийн Танхимын дарга нь аль нэг намын хараат байж болохгүй гэж үзэж байна.

Гуравт, Танхим нь улстөрд карьер хийх шат дамжлага байж болохгүй гэж боддог учраас Танхимын даргаар сонгогдовол 2024 он хүртэл аливаа улстөрийн сонгуульд оролцохгүй гэдгээ үүгээр мэдэгдэж байна. Энэ сонгуулийн хугацаанд би та бүгдтэй хамтдаа ханцуй шамлан уухайлан ажиллаж, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх ёстой болно.

Энэ бол миний өнөөг хүртэл баримталж ирсэн амьдралын зарчим, үзэл баримтлал мөн. Эдгээр жишгийг нийтлэг болгох ёстой гэж боддог тул бусад нэр дэвшигчид үүнийг хүлээн авч, дэмжин дагана гэдэгт найдаж байна.

Бид бүгд зорин нэгдэж, зориглон хөдөлвөөс хүрч болохгүй гэгээтэй аас, өөрчилж болохгүй алдаатай зүйл, гаргаж болохгүй дээд амжилт гэж үгүй болно. Монгол Улс маань үүрд бадран мандах болтугай. Бадран мандуулахын төлөө хамтдаа хөдөлө!

Гүнээ хүндэтгэн ёсолсон, Ч. Ганхуяг

2019 оны 2 сарын 20



## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ БОНД АЗИЙН ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГЫН ШИЛДЭГ БОНДООР ШАЛГАРЛАА

Эрсдэлээ 100 хувь өөрсдөө дааж, олон улсын санхүүгийн зах зээлээс 500 сая ам.долларын санхүүжилтийг Монгол Улсын Хөгжлийн банк өнгөрсөн намар буюу 2018 оны аравдугаар сарын 16-нд босгосон. Бондыг хямд, бага зардлаар, төрийн оролцоогүй амжилттай арилжаалсныг “The Asset Awards”-аас Төрийн өмчит байгууллагын шилдэг бондоор /Best Quasi-Sovereign Bond/ тодруулжээ. Үүнээс долоо хоногийн өмнө буюу энэ сарын 13-ны өдөр Азийн санхүүгийн хамгийн нэр хүндтэй, нөлөө бүхий сэтгүүл болох “Finance Asia”-ын 2018 оны шилдэг хөрөнгө оруулагч шалгаруулах ёслолоос манай улсын Хөгжлийн банкны 500 сая ам.долларын бонд мөн л “Шилдэг Хэлцэл”-ээр шалгарсан юм. Монгол Улсын Хөгжлийн банкны хувьд анх удаа Засгийн газрын баталгаагүйгээр бонд гаргасан нь манай улсын бусад зээлдэгчдийн хувьд жишиг хүү тогтоосон чухал үйл явдалд тооцогдсон билээ.

Бонд арилжаалах үед олон улсын хөрөнгө оруулагчдаас нийт 4.1 тэрбум ам.долларын бонд худалдан авах санал ирүүлсэн нь Хөгжлийн банкны санал болгосон хэмжээнээс найм дахин их байсан. Зах зээлийн эрэлт өндөр байсан нь Монгол Улс болон Хөгжлийн банк сүүлийн жилүүдэд дэлхий даяар хөрөнгө оруулагчидтай харилцаа холбоогоо сайжруулах, өргөжүүлэх арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлсний үр дүн байлаа хэмээн олон улсын шинжээчид дүгнэж байв. Улмаар олон улсын зах зээлийн нөхцөл байдал тогтворгүй байсан ч Хөгжлийн банкнаас арилжаалсан бондын хүү анх тооцож байснаас 75 суурь нэгж (0.75%)–ээр доогуур тогтож чадсан юм.

Хөгжлийн банкнаас гаргасан бонд Азийн санхүүгийн нэр хүндтэй эдгээр шагналыг ээлж дараалан хүртсэн нь эдийн засаг эрчимтэй сэргээж буйн нэг баталгаа болсон төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын нэр хүндийг өргөлөө. Эргэн сануулахад, таван жилийн хугацаатай, 7.25 хувийн купонтой арилжаалсан бондыг хөрөнгө оруулагчдад танилцуулах уулзалтуудыг Хонгконг, Сингапур, Лондон, Бостон болон Нью-Йорк хотуудад хийж байсан. Монгол Улсад итгэх гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, эдийн засгийн хүндрэлийг даван туулж Засгийн газар төдийгүй хувийн хэвшлийнхэн ч гаднын зах зээлээс хөрөнгө татахад эрсдэл буурч, хүү өртөг хямдрах нөхцөл боломж бүрдсэнийг батлан харуулснаараа “Шилдэг хэлцэл” ихээхэн ач холбогдолтой. Хөгжлийн банк он гарсаар дээрх нэр хүндтэй шагналыг гардан авсан нь манай улс эдийн засгаа эрчимтэй сэргээж буйг олон улсад хийгээд хөрөнгө оруулагчдад албан ёсоор хүлээн зөвшөөрүүлсний илэрхийлэл боллоо.

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1338.78 0.03%	6405 1.36%	98.70 0.13%	99.33 0.12%	110.70 0.12%	2,632.71	388.36	39.48



## Улс төр

БАЙР СУУРЬ

# “Дэггүй” гишүүдийн цалинг хасч шийтгэх нь өөрийгөө хуурснаас ялгаагүй

**Дэгийн тухай хуульд хариуцлагын хатуу заалт оруулах ёстой гэв**

Б.Энхжаргал  
@enkhjirgZGM

Хуралдах ёстой хугацааныхаа 30 хувьд нь ажиллаж, хууль тогтоох процесс хэвийн үргэлжлэх боломжгүй хэмжээнд тулсан УИХ-ын намрын чуулган завсарлаад удаагүй байна.

Ээлжит чуулганы туршид үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг үймж бужигналдсан парламентын гишүүд ирэх хаврын чуулганаас шинэ дэгээр хуралдана. Шинэ дэгийн тухай хуульд тусгах шинэ зүйл нь гишүүд хурууны хээгээр санал өгч, асуудалд хамааралгүй сэдвээр үг хэлэхийг хориглож, хуралдаандаа оролцохгүй бол цалингаа хасуулах зэрэг зохицуулалт юм. Парламентын нэр хүнд шалны алчуур мэт газарт унаж, төрөө хүндлэх иргэдийн итгэлийг бууруулж буйн буруутан нь хуульд биш гишүүдэд байгаа цагт дээрх зохицуулалт үр дүнгээ өгөх эсэх нь эргэлзээтэй. Тухайлбал, ажилдаа ирээгүй гишүүний цалинг хасгах. Угаасаа УИХ-ын гишүүнийхээ цалинг авах шаардлагагүй, авдаггүй гэдгийг өөрсдөө зарлаж явдаг хүмүүстэй ийм хариуцлага тооцно гэдэг өөрөө өөрийгөө хуурсантай адил. Түүний оронд нэг жилийн хугацаанд хуралдсан хуралдааны 50 хувьд суугаагүй бол УИХ-ын бүрэн эрх нь дууссанд тооцно гээд оруулчихвал арай үр дүнтэй болох буй за. Хариуцлагын хүчтэй заалтууд бүхий хуулиар л “дэггүй” гишүүдийг хариуцлагатай болгох нь ойлгомжтой.

Намрын чуулганы сүүлийн хуралдаанаар шахам томилогдсон шинэ спикерийн эхний ажил нь парламентын эвдэж нурсан эв зүйг олох гэхэд хилсдэхгүй. Тиймдээ ч УИХ-ын дэгийн тухай хуулийн хэрэгжилт, бусад орны туршлага, түүнийг нэвтрүүлэх боломжийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан юм.

Энэ үеэр УИХ-ын дэгийн тухай шинэ хуулийн талаар парламентын өмнөх удирдлагууд хэрхэн дүгнэж, ямар байр суурьтай байгааг тодрууллаа.

Шинэ спикерийн эхний ажил нь парламентын эвдэрсэн эв зүйг олох гэхэд хилсдэхгүй.



Б.Хасуй / ЗГМФ



УИХ-ын дарга асан  
**Р.Гончигдорж:**  
**ҮГ ХЭЛЭХ ЭРХИЙГ ЦӨӨНХӨД ДАВУУ ӨГӨХ ЁСТОЙ**

1996-2000 оны парламент олонхонд үүргээр олгогдсон эрхийг цөөнх зөрчиж болохгүй нь ямар чухлыг харуулсан парламент байсан.

Тэр үед 50 гишүүнтэй олонхыг 25 гишүүнтэй цөөнх хуралдаа огт боломжгүй болгож байв. Түүнээс болж Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан юм.

Харин бусад үед бүлгийн санхүүжилт үг хэлэх эрх зэрэг цөөнхөд илүү эрх мэдэл олгож байх ёстой.



УБХ, УИХ-ын гишүүн асан,  
Үндсэн хууль судлаач  
**Ц.Товуусүрэн:**  
**ГИШҮҮД ҮГ ХЭЛЭХДЭЭ ИНДЭРТ ГАРДАГ БАЙХ ХЭРЭГТЭЙ**

Парламентын индрийг хэрүүлийн талбар болгож тодордог, орчин үеийн хэллэгээр попордог байдлыг гаргахгүйн тулд шаардлагатай зохицуулалтыг Дэгийн тухай хуульд тусгах ёстой. УИХ-ын гишүүн чуулганы танхимд аливаа асуудлаар үг хэлэхдээ индэрт гарч хэлдэг баймаар байна.

Гэтэл одоо суудал дээрээсээ төгсгөл ч байхгүй, агуулгагүй юм яриад сууж байна. Босоо ярьж байгаа хүн асуудалд хариуцлагатай ханддаг. Суугаа ярьдаг учраас бие биенээ доромжилдог, хаа хамаагүй юм хамж ярьдаг.



УИХ-ын дэд дарга асан  
**Л.Цог:**  
**ХУРАЛДААН БОЙКОТЛОВОЛ ХАРИУЦЛАГА ТООЦДОГ БОЛЪЁ**

Гишүүд маш үлгэргүй байна. Төрийн нууц, хувь хүний нууцыг задалдаг боллоо. Дэгийн хуульд үүнийг нарийн тооцож, гишүүдийг эргүүлэн татах хүртэл арга хэмжээ авдаг болмоор байна. Мөн цөөнх болсон гишүүдийн үгийг сонсох асуудал. Энэ нь намын цөөнх биш. Тухайн асуудлаарх байр суурийн цөөнх. Яагаад гэвэл олонх дандаа зөв байна гэж байхгүй. Мэдээлэл, ойлголт буруу бол шийдвэр буруу л гарна. УИХ-ын гишүүн, сайдуудын амнаас Үндсэн хуулийг либераль аргаар тайлбарлах санаа гардаг. Өөрсдөдөө ашигтайгаар Үндсэн хуулийг тайлбарладаг явдал гаргахгүй байх хэрэгтэй. Түүнчлэн хуралдаан бойкотлодог байдлаар улс төр хийх тохиолдолд хуулиар хариуцлага тооцох хэрэгтэй.



УИХ-ын дарга асан  
**Д.Дэмбэрэл:**  
**ГИШҮҮД САЛАН ЗАДГАЙ БАЙДЛЫГ ӨӨГШҮҮЛСЭН ЗААЛТЫГ АВЧ ХАЯХ ХЭРЭГТЭЙ**

УИХ-ын үйл ажиллагаанд гишүүдийг салан задгай болгосон заалт Дэгийн тухай хуульд байна. Тодруулбал, 4.11 дэх заалт. Өглөө ирээд ирцэд бүртгүүлчихсэн гишүүнийг бүтэн өдөржин байгаагаар тооцдог. Гэтэл тэр нөхөр өглөө чуулганы танхимд орж ирээд түүнээс хойш байдаггүй л байхгүй юу. Санал өгөхөд бас л өөрөө байхгүй, өмнөөс нь “Тийм санал өгөөрэй гэсэн” гээд кнопыг нь дарчихдаг хүнтэй. Тиймээс салан задгай, өөрийгөө сул хаясан энэ 4.11 дэх заалтыг авч хаях ёстой гэж бодож байна. Гишүүдийн ирц бүрдэхгүй байгаа нь сайдууд давхар дээлтэй байгаагай холбож тайлбарладаг. Энэ бол арав гаруй гишүүний л асуудал. Гэтэл бусад гишүүн хаачив. УИХ-ын гишүүн багшлахаас бусдаар ажил эрхэлж болохгүй гэсэн хуулийн заалттай.

Гэтэл давхар олон даргын ажлыг өөртөө авчихдаг. Баахан төрийн бус байгууллага, холбоод, нутгийн зөвлөлийн дарга нь би байна гээд сууж байдаг. Үүнийг дэгээр хязгаарламаар байна. [ЗГМ]

## ЗГМ ТОВЧХОН

» **ТОВ**  
НИТХ-ын ээлжит бус долдугаар хуралдаан энэ сарын 26 буюу ирэх мягмар гарагт болох аж. Хуралдаанаар нийслэлийн Засаг даргын томилгоог хэлэлцэх юм.

» **НАМУУД**  
МАН-ын гишүүн А.Ганбаатарыг намаас гарсанд тооцох тухай нийслэлийн МАН-ын Хяналтын хорооны тогтоол гарчээ. А.Ганбаатар нь 60 тэрбумын гэх төлөвлөгөөг боловсруулсан хэмээгддэг юм.

» **ТОО**

15

Төсөл. Швейцарын Хөгжлийн хамтын ажиллагааны газар 2007-2016 онд манай улсад хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, мэргэжлийн боловсрол, сургалт, засаг захиргааны шинэтгэл, нутгийн удирдлага, иргэдийн оролцоо гэсэн гурван үндсэн чиглэлээр нийт 15 төсөл хөтөлбөр хэрэгжүүлжээ.

## ЭШЛЭЛ



Манайх шиг жижиг улс юунд элсэх гэж байгаагаар сайн мэдэж байх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр бодит байдал дээр хүйтэн дайн эхэлчихээд байна. Хүйтэн дайны хоёрдугаар анги эхэлсэн гэж болно. Дэлхийн том улс гүрнүүд хоёр талд хоёр том блок болж хуваагдан хоорондоо худалдаа хийж байна. Нэгэнт хүйтэн дайн эхэлчихээд байхад Монгол Улс том гүрнүүдийн зодоонд өөрөө гүйж орох хэрэггүй. Би үүнийг аюултай гэж боддог. Хоёр хөрштэйгээ найрсаг, гүн хамтын ажиллагаатай, аль нэгнийх нь нөлөөнд хэт автаагүй, гуравдагч хөрштэй, олон тулгуурт гадаад бодлоготой байх нь Монголын эрх ашиг.

УИХ-ын гишүүн  
**Ц.Мөнх-Оргил**

## ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжигатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» **INFO@ZASAG.CO**

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

## ЗАСГИЙН ГАЗАР

### Засаг дарга нарыг ядуурал бууруулснаар нь дүгнэнэ

Засаг дарга нар ажилгүйдэл, ядуурлыг хэр зэрэг бууруулснаар ажлыг нь дүгнэнэ гэдгийг Ерөнхий сайд У.Хүрэлсүх аймаг, нийслэл, сум, дүүрэг, тосгон, хорооны Засаг дарга нарт анхааруулав.

Улмаар ажлын байр бий болгож байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч, хувиараа хөдөлмөр эрхэлж

байгаа иргэд, баялаг бүтээгчдээ бүх талаар дэмжихийг чиглэл болгосон юм. Төрийн оронд орон нутгийн удирдах ажилтны хамтран ажиллах хүсэлт тавьсан. Хуралдааныг нээж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ үг хэлэв. Тэрбээр “төрийн албаны шинэчлэл, эдийн

засгийн бүсчилсэн хөгжил, Үндсэн хуулийн өөрчлөлт, байгалийн баялгийг иргэддээ хүртээмжтэй хүртээх, төрийн үйлчилгээг цахимжуулж, хүнд сурталгүй үйлчлэх зэрэг сэдвийг хэлэлцэх энэ зөвлөгөөн улс орны хөгжлийг 20-25 жилээр харна гэдэгт итгэлтэй байна” гэв. [ЗГМ]

### Шинэ төмөр замын бүтээн байгуулалтад ОХУ оролцох сонирхолтой байна

Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан ОХУ-ын Тээврийн яамны орлогч сайд В.А. Токаревыг хүлээн авч уулзав.

Энэ үеэр бус нутгийн хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Новосибирск, Красноярск хотууд руу шууд нислэг үйлдэх, эдгээр хотуудаар дамжин гуравдагч улс руу нислэг үйлдэх боломжийг

судалж, дэмжлэг үзүүлэхийг Оросын талаас хүсэв. Мөн тус улсын агаарын навигацийн шинэ технологийг ашиглах чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавьсан юм. Харин “УБТЗ” ХНН-ийн суурь бүтцийн их засвар, хөдлөх бүрэлдэхүүний шинэчлэл болон шинээр баригдах төмөр замын бүтээн байгуулалтад ОХУ хамтран

ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийллээ.

Энэ үеэр Монгол Улсын ачаа, түүний дотор уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан гуравдагч зээлд гаргахад бүх талын хөнгөлөлт олгох, Монголын вагоныг ОХУ-ын төмөр замаар аялуулах талаар тохиролцоо. [ЗГМ]

## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 02 дугаар сарын 22

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн цаасан хэрэглэл нийлүүлэх ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: МИАТ/201901003**

**МИАТ ТӨХК эрх** бүхий тендерт оролцогчдоос Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн цаасан хэрэглэл нийлүүлэх цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эхсүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- 1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны нийт борлуулалт тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх,
- 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,
- 3. Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх,

**Тендерийн хамт багц 1-т 9,867,000 төгрөгийн, багц 2-т 5,912,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.**

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар тендерийн нэг баталгаа гаргаж болох бөгөөд багц тус бүрийн баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай. Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11.00 цаг-аас өмнө** цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) /-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж PDF 1 файлаар цахим хэлбэрт шилжүүлэн ирүүлэх ба тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11.30 цаг -т нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэхийг зөвшөөрнө.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МИАТ ТӨХК. Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45, МИАТ ТӨХК-ийн төв байр**  
Хангамж, үйлчилгээний хэлтэс 103 тоот  
Утас: 70049860, факс: 70049919



## Нийтлэлчийн булан

ЖДҮХС-гийн хэргийг АТГ, ЦЕГ-ын 50 байцаагч, 20 прокурор оролцсон ланжгар бүрэлдэхүүн гурван сарын турш мөрдөн шалгаж байна.



Б.Хасуй / ЗГМӨ

байгаа биз. Тиймдээ ч хаврын чуулганаас өмнө ЖДҮХС-гийн дуулианыг дарах шинэ шуугиан гаргаж ирэхээр давчдаж байгаа нь энэ буюу. Нөгөөтэйгүүр, МАН-ынхан алдсан нэр хүндээ өсгөдөггүй юмаа гэхэд өмнөх эрх баригчдын рейтингийг өөрсдийнхөө дөхүүлэх нь сонгуульд ойролцоо санал авах эцсийн найдвар хэмээн тооцоолж байгаа нь ч илт.

“ЖДҮ”-чин гишүүдийн булхай мартагдахын сацуу намын нэр хүндээ аварна гэдэг яаж ч бодсон МАН-ынханд ашигтай төлөвлөгөө. Тийм ч учраас “ЖДҮ”-чин гишүүд шинэ шуугианыг сэвж, олон нийтэд дэвэргэхээр өндөлзөн сууна. Сэвэх, шивэх хөлсний бичээчид ч даалгавраа хүлээн “гарааны зурхайд” хэл амаа шилэмдэн байна. Яг л нийслэлийн нэгэн прокурорын хууль бусаар авсан газруудыг хотын захирагч хураах дуулиан дэгдээд эхэлмэгц социалаар нийслэлийн Засаг даргыг бэлгийн өөр чиг хандлагатай мэтээр гүтгэж

# “ЖДҮ”-чин гишүүд шинэ дуулианыг сэвж буйн шалтгаан

**ЖДҮХС-гийн хэрэгт шинэ шуугианаар хуучин дуулианыг дарах технологи ашиглана**

Г.Батбөх  
ЗГМ

Өөрийнхөө алдааг дүйвүүлэхийн тулд бусдыг муулдаг арга өнө эртнээс өнөөг хүртэл улбаалсныг монголчууд сайн мэднэ дээ. Басхүү хулгайч хүн бусдаас чангаар “хулгайчийг бариарай” гэж хашхирдаг гэдэг.

Балаг нь дарагдах биш цагийн эрхээр дурайтал тодорсон жишээ ч олон бий. Үүнийг бид “даравч дардайна, булавч бултайна” гэх товч үгээр зүйрлэн хэлдэг. Ялангуяа, улс төрийн хүрээнд өөрсдийн бурууг нуухын

тулд өрсөлдөгчийнхөө алдааг сөргүүлэн дэлгэдэг арга баг суурьшин нутагшсан. Наад зах нь эрх барьж буй нам өмнөхөө харлуулж рейтингээ өсгөх тактик барьсаар ирсэн нь Монголын улс төрд шалгарсан ноу хау болоод байна.

Харин сүүлийн үед дуулианыг шуугианаар дарах оролдлого улс төрийн гол технологи болжээ. Үүний тод илрэл ЖДҮХС-г цөмлөгчдийн хэргийг замхруулах учиртай төлөвлөгөө.

УИХ дахь МАН-ын бүлгийн хагарал дээд цэгтээ хүрэх үед гарч ирсэн “60 тэрбумын хэрэг” гэх дуулианыг намжаахын тулд ЖДҮХС-тай холбоотой хэргийг дэлгэх болсон нь үнэн билээ.

УИХ-ын гишүүд ЖДҮХС-гаас мөнгө авсан шуугиан өнөөдөр дуулиант хэргийн тоонд баттай жагсаж, зээл авсан, нөлөөлсөн гишүүд нь ч эхнээсээ тодорсоор байгаа. Тус хэргийг 50 байцаагч, 20 прокурор оролцсон ланжгар бүрэлдэхүүн гурван сарын турш

● **ЖДҮХС-гийн эсрэг дуугарсан намын нөхдөө нам дарж авсан тэд “Б” төлөвлөгөөнийхөө дагуу Хөгжлийн банкны төслүүдийг хөөрөгдөхөөр бэлтгэж эхэллээ.**

● **Сөрөг хүчин ЖДҮХС-тай холбоотой хэргийг МАН-ын “зодоон”-оос тусад нь авч үзэхээ илэрхийлж хаврын чуулганаар хэлэлцэхээр ээхэж буй нь “ЖДҮ”-чин гишүүдэд аюулын харанга дэлдэв.**

● **МАН-ынхан алдсан нэр хүндээ өсгөдөггүй юмаа гэхэд өмнөх эрх баригчдын рейтингийг унагаах нь ирэх сонгуулийн гол бэлтгэл.**

мөрдөн шалгаж байна.

Мөрдөн байцаалтын явцад УИХ-ын олон гишүүний нэр уг хэрэгт холбогдож зарим нь парламентын гишүүний эрхээ хасуулах дээрээ тулж ах нарынхаа ачаар аврагдсан нь парламентын түүхэнд хар толбо болон үлдлээ. Прокурорын зүгээс УИХ-ын дөрвөн гишүүнийг ЖДҮХС-гийн хөрөнгийг мөнгө угаахад зарцуулсан гэдгийг нотлох баримттай нь гаргаж эрхийг нь түдгэлзүүлэн шалгах аар танилцуулсан боловч Халдашгүй байдлын дэд хорооны дүгнэлтээр тэднийгээ ил цагаанаар авч үлдсэн.

Дахиад таван гишүүнийг ЖДҮХС-тай холбоотой хэрэгт нь шалгах хүсэлтэй байгаагаа Ерөнхий прокурор мэдэгдэж буй энэ цаг үед хэргээ дарах шуугиан бодож олох нь “ЖДҮ”-чин гишүүдийн туйлын хүслэн болов. Өөрөөр хэлбэл, өөрсдөөс нь илүүтэй дуулианыг босгож сэвэх “Б” төлөвлөгөөндөө шамдлаа. ЖДҮХС-гийн эсрэг дуугарсан

намын нөхдөө нам дарж авсан тэд “Б” төлөвлөгөөнийхөө дагуу Хөгжлийн банкны төслүүдийг хөөрөгдөхөөр бэлтгэж эхэлжээ. Ирэх хаврын чуулганаар АН-ыг УИХ-д бүлэггүй болгож дуу хоолойг нь намсгах бодлого ч үүний нэг салбар төлөвлөгөө юм.


**“МАН мартавч, мань мартахагүй” гэдэг үг социалд хүчээ алдаагүй хэвээр**

Сөрөг хүчний зүгээс ЖДҮХС-тай холбоотой хэргийг МАН-ын “зодоон”-оос тусад нь авч үзэхээ илэрхийлэн хаврын чуулганаар хэлэлцэхээр ээхэж буй нь “ЖДҮ”-чин гишүүдэд аюулын харанга дэлдэх мэт сонсогдон бачимдаж

шуугиан дэгдээж нам дарсан шиг. Үүнийг олны дунд уусгах тактик буюу нийтийн анхаарлыг өөр тийш шилжүүлэх технологи хэмээвэл зохилтой. Хэдий чинээ олон сенсац дэгдээн төдий чинээ өмнөх дуулиан бүдгэрдгийг өмнөх жилүүдэд социалаар хөвөрч эцэстээ “зэвэрсэн” сэдвүүд харуулсан болохоор тэд амжилттай болно хэмээн горьдлого тээн амьсгаа даран хүлээж сууна. Харин үүндээ Монголын эдийн засагт жинтэй нэмэр болсон Хөгжлийн банкны зээлийг “барьцаалах” нь шал өөр явдал гэдгийг ухаарахгүй байгаа бололтой.

Нотлох баримттай, ноогдох ял нь тодорхой болсон ЖДҮХС-гийн хэрэгт холбогдсон гишүүд “арьсаа” хамгаалах сүүлийн найдвар социалд шинэ сенсац дэгдээж өөрсдийгөө мартагнуулах явдал болоод байна. Гэвч “МАН мартавч, мань мартахагүй” гэдэг үг социалд хүчээ алдаагүй байгааг сануулах юун. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



©2019 S. Tsogtбаяр ZGM



## Нийгэм

# Хуулийн цоорхой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хохироож байна

**Хөдөлмөрийн насны ажил хийдэггүй 75 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн бий**

Г.Санжааханд  
ЗГМ

Ид хийж бүтээх насных ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй улмаас ажил хийж чадаагүй 80 мянган хүн Монголд байна. Харин өнгөрсөн оны байдлаар тэдний 2500 нь ажил хайгчаар бүртгүүлж, ердөө 25 хувь нь ажилд зуучуулан оржээ. Гэхдээ тэд ажилд орох гэж бүртгүүлээд хамгийн багадаа хагас жил хүлээдэг аж. Тиймээс зарим нь замаасаа шантардаг гэсэн судалгааг Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт гаргасан байна.

Хөдөлмөрийн тухай хуулиар аж ахуйн нэгжүүд 25, түүнээс дээш ажилтантай бол түүний дөрөвт нь хөгжлийн бэрхшээлтэй болон одой иргэн ажиллуулах ёстой. Гэвч энэ хуулийн хэрэгжилтийг биелүүлэх, шалгах механизм тун муу. Тиймээс аж ахуйн нэгжүүд дээрх хуулийг биелүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авахад хойрго хандсаар байна. Харин ч хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулахгүйн төлбөрийг төлөөд явах сонирхол өндөр байдаг аж.

2018 оны байдлаар дээрх төлбөрийг 273 аж ахуйн нэгж, байгууллага төлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 969.1



Б.Хасуй / ЗГМӨ

сая төгрөг шилжүүлжээ. Уг нь тус хуулийн заалтыг хэрэгжүүлэх нийт 5230 шимтгэл төлөгч байгууллага Монгол Улсад бүртгэлтэй аж. Хөдөлмөрийн тухай хуулийн тус заалт бүрэн хэрэгжсэн бол дор хаяж 15 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болох байсан. Шимтгэл төлж байгаа байгууллагаас төлбөр төлж буй шалтгааныг асуухад 50 орчим

хувь нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилд орохоор хандаж байгаагүй” гэж хариулсан байна. Харин 26 хувь нь эдгээр иргэнд ажиллах боломжтой ажлын байр байхгүй, 20 хувь нь ур чадвар шаардлагад нийцдэггүй гэжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга Ц.Ганчимэг “Тухайн байгууллага хэдэн төгрөгийн төлбөр төлөх нь

ажилчдынх нь тооноос хамаарна” хэмээн хэлэв. Ийнхүү ажилд орох гэсэн ч тэнцдэггүй, хайгаад ч олддоггүй гээд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэр зуур байхаас өөр сонголт үлдсэнгүй. Харин тэдэнд улсаас сар бүр 174 мянган төгрөгийн тэтгэмж олгодог бол, улиралд нэг удаа асаргааны мөнгө гэж 78 мянгыг нэмж өгдөг аж. Тэгэхээр үүнээс өөр ямар ч

орлогогүй тэд сард ердөө 200 мянган төгрөгөөр амьдралаа залуулдаг гэсэн үг.

Харин ажил хийж буй 20 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэний дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг аж. Эрүүл мэнд, боловсрол, ус хангамжийн салбарт цөөн тооны хүмүүс ажиллагчийг албаны хүн дурдсан юм. [ЗГМ]

## Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1-ийн хэрэгжилт (биелэлтийн хувь)



## НИЙСЛЭЛ

### Зуун айлыг дэд бүтэцжүүлэх боломжгүй болжээ

Б.Сэлэнгэ  
ЗГМ

“Зуун айлын барилгын материалын зах, худалдааны төвийг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх ажлын хэсэг”-ийг нийслэлээс байгуулаад буй. Тус ажлын хэсгийнхэн тухайн бүсэд дахин төлөвлөлт хийхээр төлөвлөж буй хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтад нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, нийслэлийн Авто замын хөгжлийн газар, нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар болон барилгын компаниудын төлөөллүүд оролцсон юм.

Ажлын хэсгээс үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг уулзалтын эхэнд хийсэн. Харин хөрөнгө оруулагчид тулгамдаж буй асуудлаа хэллээ. Тухайлбал, барилга барихаар төлөвлөсөн XI хорооны хэсэгт дэд бүтэц, дулааны

шугам татах боломжгүй байгаа аж. Мөн айлуудаас худалдан авсан газрын өмчлөлөө эргүүлээд аж ахуйн нэгжээр бүртгүүлэхэд 20-30 хувийн татвар төлөх шаардлагатай болж байгаа. Энэ нь хөрөнгө оруулагчдад дарамт үүсгэж байгаа аж. Түүнчлэн авто зам төлөвлөлт, хүн амын төвлөрөл, хөрсний усны асуудал ч бэрхшээл дагуулж буйг оролцогч байгууллагууд уламжиллаа.

“Бид хөрөнгө оруулагч болон гүйцэтгэгч талуудыг ажил эрчимжүүл хэмээн шаардахаас илүүтэй төрөөс хийх ёстой тулгамдсан асуудал олон байгаа нь өнөөдрийн уулзалтаас харагдаж байна. Иймд бид НИТХ-д болон холбогдох хороодод хандсан зөвлөмж гаргахаас гадна ажил эрчимжүүлэх зарим нэг саналыг Засгийн газарт хүргүүлж ажиллах болно” гэдгийг ажлын хэсгийн ахлагч, НИТХ-ын төлөөлөгч Ч.Гантулга хэлсэн үгэндээ тодотголоо. [ЗГМ]

## Цахимаар ирүүлсэн 90 зөрчилд хариуцлага тооцов



Б.Хасуй / ЗГМӨ

Замын хөдөлгөөнд оролцож буй жолооч нар урсгал сөрөх, тэмдэг тэмдэглэгээ зөрчих, “зогс” шугам давж зогсох, уулзвар гарц хаах, уулзварт давхар эргэх, эгнээ хааж зогсох, эгнээ байр буруу эзлэх, гэрлэн дохио зөрчих гэх мэтээр замын хөдөлгөөний дүрмийг их зөрчдөг. Үүний улмаас түгжрэл үүсч, хөдөлгөөний ачааллыг ихэсгэж байгаа. Тиймээс замын

хөдөлгөөний соёлыг дээшлүүлэх, зөрчлийг бууруулах, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор Замын хөдөлгөөний удирдлагын төв, Тээврийн цагдаагийн албатай хамтран E-Police аппликейшнээр хамтран ажиллаж байгаа юм. Өнгөрсөн долоо хоногт E-POLICE гар утасны апплекэйшнээр ирүүлсэн 90 зөрчилд хариуцлага тооцсон байна. [ЗГМ]

## ЗГМ ТОВЧХОН

### » АЯН

Сонгинохайрхан дүүрэгт хүүхэд багачуудыг соён гэгээрүүлэх, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд нь зориулж дөрвөн байршилд номын сантай цэцэрлэгт хүрээлэн байгууллаа. Үүнтэй холбогдуулан тус дүүргийн Засаг дарга Ж.Сандагсүрэнгийн санаачилгаар “Ном хандивлах” аяныг эхлүүлжээ.

### » ҮЗЭСГЭЛЭН

Өчигдөр Богд хааны ордон музейд “Гайхамшиг өв соёл-монгол уран хатгамал” үзэсгэлэн нээлтээ хийлээ. Энэхүү үзэсгэлэн ирэх гуравдугаар сарын 1-нийг хүртэл үргэлжилнэ.

### » ЦАГ АГААР

ЦУОШГ-аас хоёр, гурав, дөрөвдүгээр сард нийт нутгаар олон жилийн дунджаас 0,5-1 хэмээр дулаан байна гэв. Хур тунадасны хувьд нутгийн хойд хэсгээр дунджаас ахиу, бусад нутгаар ялангуяа нутгийн зүүн хагаст дунджаас бага хур тунадастай, хаврын улиралд нийт нутгаар хуурайшилт өндөр байх аж.

### » ШҮҮХ ХУРАЛ

“Очир” төвийн буудлын өрөөнд 13 настай охиныг онц хэрцгийгээр хөнөөсөн М.Амарболд, Б.Жавхлан нарын шүүх хурал өчигдөр Нийслэлийн давж заалдах шатны шүүхэд боллоо. Тус шүүх хурлаар анхан шатны шүүхээс оноосон ялыг хэвээр үлдээсэн байна.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **“Тоног төхөөрөмж” буюу “Суудлын автомашин” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер.**  
Тендер шалгаруулалтын дугаар: МУУХЦТГ-2019/НТШ-ТТ2

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар** эрх бүхий тендерт оролцогчдоос **“Суудлын автомашин”**-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдлээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын талаар дараахь шаардлагыг хангасан байна.

### Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жил санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас доошгүй.
- Түргэн хөрвөж чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй байна.
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 он.
- Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлага (төсөв).**

**Тендерийн хамт 1,400,000 (нэг сая дөрвөн зуун мянга) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**  
**Засгийн газрын бонд, Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасыг ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.**

Тендерийг 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 11 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Тийм.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн гудамж, Үндсэн хуулийн цэцийн байр, 1 дүгээр давхар, 106 тоот, өрөө. www.tender.gov.mn. Утас: 62260082, 88114022**

## [ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгэл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга  
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**

Ерөнхий эрхлэгч  
**Батарын ДУЛАМХОРЛОО**

Зөвлөх  
**Шатарбалын ДАВААДОРЖ**

Орлогч эрхлэгч  
**Лхагважавын СУГАРМАА**  
Утас: 99903584

**РЕДАКЦ**

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба  
**Эдитор Б.Энхжаргал**  
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
**Эдитор Г.Баярсайхан**  
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба  
**Эдитор З.Цэлмэг**  
Утас: 99901526

**ЗАР СУРТАЛЧИЛГАА**

Утас: 99903581  
99903578  
99907843

**ХАЯГ**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,  
“Блю Скай тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар. 1024  
Утас: 70103131,  
Факс: 7010606

**ЦАХИМ ХУВИЛБАР**

zgm.mn  
ubinfo.mn  
Дугаарын удирдагч  
Л.Сугармаа

8465000429112 001085



ЗГМ: Зочин

Бөхийн хоёр өөр төрлөөр дэлхийд амжилт гаргасан хүн Х.Баянмөнх бид хоёр л байдаг юм

УИХ-д суугаад мөнгө идээд байгаа нөхдийн оронд Н.Түвшинбаяр сонгогдох л ёстой байхгүй юу

Г.Баярсайхан @bayarsaikhanZGM

Монгол Улсын гавьяат тамирчин Н.Бүргэдаг сонинхоо хүндэт зочноор урьж ярилцлаа.



С.Батсайхан / ЗГМӨ

Таны бие тэнхээ сайн уу. Лагшин муудаад сувилалд хэвтэв үү, эсвэл зүгээр тэнхрэх зорилготой юу?

Сайхан хаваржиж байна аа. Нас 60 гараад явчихсан хүн чинь хаваргаа нэг сувилуулахгүй бол болохгүй юм.

салбар хариуцсан яам анхаарлаа тавьж, өмөөрөх ёстой байсан ч тэгсэнгүй.

Та чөлөөт бөхийн холбооны дэд ерөнхийлөгч хэвээрээ юу?

Мөөгөө аварга, З.Ойдов, бид хэд ярилцаж байгаад холбооноос гарсан шүү дээ. Холбооны хэд маань хоорондоо муудалцаж эвдрэлцээд салахгүй юм.

Та спортын талбарт амжилт гаргаж, дэлхийн аваргаас медаль авсан дэлхийн хэмжээний тамирчин. Тамирчны замналаа

эргээд харахад харамсах зүйл байдаг уу?

Өмсгөлтэй, өмсгөлтгүй бөхийн хоёр өөр төрлөөр дэлхийд амжилт гаргасан хүн Х.Баянмөнх бид хоёр л байдаг юм.

1980 оны Москвагийн олимпод би дэлхийн томчуудыг бүгдийг хоцсон хэрнээ Унгарын бөхөд ялагдчихсан. Тэр орой барилдаантай гэж хэлээд миний жинг тавиулчихсан.

Дараа жил нь ДАШТ-д манайхан бүгд мултрахад би ганцаараа хүрэл

медальтай ирсэн. Манайхан ер нь оросуудтай тааруухан барилддаг бол би эсрэгээрээ, орос бөхчүүдэд бараг ялагдаж үзээгүй дээ.

1982 он бол миний хамгийн сайн байсан жил. Тэр жил оролцсон тэмцээн болгоноос медальтай ирсэн. Гэвч дэлхийн аваргад орж чадаагүй.

1983 онд самбо, чөлөөтийн ДАШТ-ийг хоёуланг нь Киевт зохион байгуулахаар болсон. Би тэр жил самбын улсын аварга болж, олон улсын бүх тэмцээнд нь түрүүлээд байв.

Хэдийгээр би зохих ёстой амжилтаа гаргаж чадаагүй ч хувь заяандаа баярлаж явдаг юм.

Ж.Мөнхбат аварга надад “Чи 1982 онд яваад дэлхийн аварга болчихсон бол, самбод дөрөв, тав түрүүлсэн бол хэнхэлдгээ дэлссэн, архи уусан хулигаан явж байхгүй юу. Харин дутуу амжилт гаргасны чинь хариуд бурхан чамд сайхан амьдрал бэлэглэвээ.”

Та Х.Баттулга Ерөнхийлөгчтэй самбын дэвжээнд таарч байв үү?

Хоёр удаа таарч, нэг ялаад нэг ялагдсан. Төрөлхийн авьяастай, хөдөлмөрч хүн л дээ. Нэг удаа “Алдар” дээр улсын аварга боллоо. Жингийн үзлэг дуусах гээд байдаг. Баттулга байдаггүй.

хүртэл гүйсээр байгаад ирсэн байгаа юм. Энэ хооронд гүйхэд тэдэн кг хасагдана, тэгээд жиндээ орно гэж тооцсон хэрэг. Тэр үед “Энэ мөн агуу хүүхэд юм даа” гэж бодож байлаа.

Та спортын замналаа өндөрлүүлсний дараа бизнесийн салбарт ч бас амжилт гаргасан хүн. Бизнеснст анх хөл тавьсан үеэ дурсвал?

Тамирчны замналаа дуусгасны дараа нэг хэсэг дасгалжуулагч хийдэг байлаа. Ингээд явж байтал 1990 он гарч, зах зээлд шилжив.

Удалгүй нөгөө газар дээр спортын том цогцолбор барина гэж дүүргээс гэрээ байгууллаа. Гэтэл дараа нь гэрээгээ зөрчөөд долоон давхар барилга барьчихсан юм.

Чөлөөт бөхийн мөнгөн үеийнхэн их хэлмэгдэж, хохирсон доо

Та тамирчин ахуйдаа бас бага сага наймаа хийчихдэг байсан гэл үү?

Тамирчид наймаа хийнэ гэж юу байхав. Харин тэр үед ченж хүйтэй гэж байлаа. Манайхан үстэй малгай, цэрэг шинель, лууны зурагтай шаазан гүц, шаазан морь зэргээ аваад явна.

бол нутагтаа очоод шүүхэд дуудагдана шүү” гэж байна. Ялсаар байгаад аваргын төлөө Оросын бөхтэй таарлаа. Барилдахын өмнө Мөнхбат аварга хүрч ирээд “Чиний 500 рублийг хураадаг хүн чинь бага ястан байсан.

Та өнгөрсөн сонгуульд МАХН-аас нэр дэвшин өрсөлдсөн. Яагаад улс төрд орохоор шийдэв, яагаад энэ намыг сонгов гэдэг нь сонирхолтой санагдаж байна?

Өнөөгийн нийгмийг харахаар улс төрд орохоос өөр сонголт алга. Юм үзэж, нүд тайлаад ирэхээр Монгол Улс буруу замаар яваад байгааг илүү их ойлгож юм.

Намд элсэе гэхээр хэдхэн сонголт байна. МАН-д миний ах бий. Энэ нам маш олон жил төр барихдаа юу хийж гийгүүлэв. Хотын дарга гэхэд дандаа энэ намынхан байсан.

Та тамирчин нөхөр хөёрыгөө бодвол дээр, шинэчлэгдэж байгаа нам гэж бодоод шинэ юм хийхийн төлөө орсон. Одоо би 300 гаруй мянган хүн амтай Баянзүрх дүүрэгт МАХН-ын дарга хийж байна.

Тамирчид, бөхчүүд улс төрд орлоо гэх шүүмэлд бий. Та үүнд ямар хариулт өгөх вэ?

Олимп, дэлхийд өндөр амжилт гаргаж бай мундаг тамирчид, бөхчүүд байна. Эд нар нийгмээсээ арай түрүүлж хөгжсөн, юм үзэж нүд тайлсан, эх оронч үзэл суусан хүмүүс байдаг юм. УИХ-д суугаад мөнгө идээд байгаа нөхдийн оронд Н.Түвшинбаяр сонгогдох л ёстой. Энэ хүн Булган аймаг, Баянхонгорын төлөө зүтгэнэ үү гэхээс оффшорчидтой нийлээд мөнгө идэхгүй л байхгүй юу.

Ирэх жил УИХ-ын сонгууль болно. Та өрсөлдөнө биз дээ?

Одоо би аль ч намд сүжигтэй болоод байгаа. Нам гэдэг ардчилсан сонгууль нэрийн дор дээрмийн бүлэглэл байгуулдаг бүтэц болж хувирлаа. Тиймээс миний ард түмэн нам гэдэг зүйлээ боль оо. Та нар тойрогтоо хэнийг нэр дэвшүүлэх хүсэлтэй байгаагаа өөрсдөө хэлдэг болох цаг ирсэн.

Миний хувьд аль ч намаас нэр дэвшихгүй. Хэрэв дургүй хүргээд байвал нутагтаа бие дааж нэр дэвшинэ. Говь-Алтайгаас сонгогдсон УИХ-ын гишүүд бүгд муу юманд холбогдоо. Сүүлийн үед “Би танай нутгаас гаралтай” гээд цүнх барьсан нэг нөхөр хотоос ирж сонгогдчихоод алга болчихдог болж.

Илэн далангүй ярилсанд баярлалаа. [ЗГМ]

Advertisement for Millennium Challenge Account (MCA) - Mongolia Closing Date: 17.00 ULAT, March 15, 2019. About MCA-Mongolia: The Government of Mongolia seeks qualified individuals to help organize, manage and lead a new special purpose entity to be known as the Millennium Challenge Account - Mongolia ("MCA-Mongolia").



## Технологи

Хоригдлуудад GPS зүүлгэж  
ЭХЭЛЛЭЭС.Энэрэл  
ЗГМ


Их Британи улс олон мянган хоригдолтой. Тэднийг хараа хяналттай байлгах үүднээс энэ зунаас эхлэн биед нь GPS суулгаж эхлэх гэж байна.

Энэхүү GPS-ийн тусламж-

тайгаар тэднийг хэр хүмүүжилтэй байгааг хянаж, улмаар сайн хүмүүжигч болбол шоронд суух хугацааг нь багасгах боломжтой болох юм.

Уг санааг өмнө нь туршиж амжилттай хэрэгжсэн иул ийн хоригдож буй хүмүүжигч нарт суулгахаар болжээ. Тус улс жил бүр 4000 хүнд шинээр GPS зүүж

өгөх боловч хоригдлууд байнгын хяналтад орохоос татгалзаж, хүний эрхэнд бүдүүлгээр халдаж байна хэмээн эсэргүүцсэн аж. Гэвч GPS нь гэмт хэрэг буурах боломжийг нэмэгдүүлэх юм.



## Xiaomi Xiaoi ухаалаг чанга яригч Mi 9-ийг танилцуулав

Xiaomi Xiaoi саяхан Mi 9 болон Mi 9 SE ухаалаг утаснууд болон мэдрэгч дэлгэцтэй шинэ чанга яригчийг таницуулла. Энэхүү чанга яригчтай, мэдрэгч дэлгэцийг “жигжиг телевиз” болгон ашиглаж ч болох бөгөөд дөрвөн инчийн хэмжээтэй хийсэн байна. Мөн дуу хоолойны өнгийг ялгах нэмэлт тохиргоотой ба гэртээ байгаа бүх ухаалаг төхөөрөмжүүдийг удирдах боломжтой ажээ. Тухайлбал, хэн нэгэн хүн гэрийн хаалга цохиж байгааг тань энэхүү ухаалаг чанга яригч танд мэдэгдэх чадвартай аж. Тус бүтээлийг зохион бүтээгчид сэтгэл нэн хангалуун байгаагаа мэдэгджээ.

Huawei P30 Pro загвар  
сайжруулсан дөрвөн камертай

Huawei компанийн танилцуулсан Huawei P30 загварын шинэ гар утас нь ардаа дүрсний өндөр чанартай, супер таталттай дөрвөн камертай болжээ. Watermark P30 Pro уг загварт дүрс бүрсийлгэгч, усанд зураг саадгүй дарагч хоёр камерыг нэмэлтээр оруулж өгсөн нь хэрэглэгчдийг татах болов.

Мөн холын дүрсийг маш өндөр чанартайгаар тав дахин томсгон

татаж, цэвэрхэн авах хүчин чадалтай. Өмнөх P20 Pro загвар нь гурван камерны тохируулгатай байсан бөгөөд худалдан авагчдыг татаж чадсан. Харин өмнөх туршлагадаа үндэслэн P30 Pro-д snapper оруулснаар мэргэжлийн гэрэл зураг авах боломжийг бүрдүүлээд байгаа юм. Зургийн нягтаршил нь 1080x2340 учир гэрэл зургийн аппаратыг ч орлох бүрэн боломжтой аж.

Dell Alienware өмнөх загвараасаа  
илүү багтаамжтай

Энэ сарын сүүлээр Dell G5 болон G7 загварыг нийтэд танилцуулах гэж байна. G5 загвар нь 15 инчийн дэлгэцтэй, харин G7-ыг загвар 15 болон 17 инчийн сонголттойгоор худалдаанд гаргах аж. Өмнө нь гаргаж багтсан тоглоомонд зориулсан зөөврийн компьютеруудаас олсон туршлагадаа үндэслэн энэхүү G загварт нэмэлт хэдэн өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, G Series дээр нэмэлт хийж, GeForce GTX 1060 болгон өөрчилж болно. GTX 1070 болон GTX 1080 зэрэг хүчирхэг картуудыг Dell-ийн Alienware-д нэмэлтээр оруулсан нь хэрэглэгчдийн сонирхлыг татна гэж найдаж байгаа ажээ.

## Хятад улс мэдээний "робот хөтлөгч"-тэй боллоо

Хятад улс хэвлэл мэдээллийн салбарт цоо шинэ дэвшил гаргах гэж байгаа тухай Синьхуа агентлаг мэдээллээ. Тус улсын төв телевиз Sogou компанитай хамтран мэдээний эмэгтэй, эрэгтэй хөтлөгчдийг орлох хиймэл оюун ухаантай робот зохион бүтээжээ. Энэхүү хиймэл оюун ухаант роботууд ирэх гуравдугаар сард эфирээр анхны мэдээгээ хөтлөх ба Хятадын төв телевизийн өглөөний мэдээг тэрхүү

роботуудаар хөтлүүлэхээр төлөвлөж байна. Хөтлөгч эмэгтэй роботын нэрийг Шин Шаомэн (Xin Xiaomeng) харин хамтран хөтлөгч “эрэгтэй”-г нь Кюу Хао (Qiu Hao) гэж нэрлэжээ.

Синьхуа агентлагийн мэдээлж буйгаар эдгээр шинэ хөтлөгч 10 мянган минут буюу 167 цагийн турш 3400 мэдээ давтан уншиж дасгал хийсэн аж. Хиймэл оюун ухаант хөтлөгчдийн санах ойд унших

текст байршуулсанаар мэдээг ямар ч саадгүй хүргэх боломжтой гэнэ. Энгийн хүмүүсийг бодоход сандрах, гацах зэрэг асуудал огт гарахгүй гэж үзсэний үндсэн дээр уг роботуыг хийх санааг сэдсэн аж. Мөн зарим тохиолдолд урт цагаар мэдээллийн хөтөлбөр дамжуулах шаардлага тулгарахад ашигтай ажээ. Дараагийн загвараар цаг агаарын хөтлөгч хийх зорилттой байгаа талаараа Синьхуа агентлаг мэдэгдлээ.



Ирээдүйд хөтлөгчдийг робот орлоно.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.02.22

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Ус сувгийн удирдах газарт дэлгэц нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР:** УСУГ-ХА-2019-69

**Ус сувгийн удирдах газар** эрх бүхий тендерт оролцогчдоос **дэлгэц нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны дундаж нь төсөвт өртгийн 100%-с дээш байх.

Тендерийн хамт 2,000,000 /хоёр сая / төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

**Хүчинтэй байх хугацаа:** 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг дуустал.

Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 цаг 30 минут-аас** нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар**  
**Утас: 70157018-223**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.02.22

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Ус сувгийн удирдах газарт зэвэрдэггүй ёмкость нийлүүлэгчийг сонгон шалгаруулах.

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР/ГЭРЭЭНИЙ ДУГААР:** УСУГ-ХА-2019-70

**Ус сувгийн удирдах газар** эрх бүхий тендерт оролцогчдоос **зэвэрдэггүй ёмкость нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер** ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

Сүүлийн 1 жил буюу 2018 оны Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд буюу 2017, 2018 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ. Борлуулалтын орлого нь сүүлийн 1 жил буюу 2018 онд төсөвт өртгийн 100%-с дээш байх.

Тендерийн хамт 1,600,000 /нэг сая зургаан зуун мянган/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

**Хүчинтэй байх хугацаа:** 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг дуустал.

Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минут-аас** нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар**  
**Утас: 70157018-223**



# ZGM DAILY

## An 18-months old infant sent to his second surgery abroad

Pediatric cancer increases among newborns.

## Wealthiest group accounts for 39.5 percent of total consumption

Poorest 20 percent of population makes up 7.7 percent of national consumption.

## Sales revenue of TTP IV rises to MNT 4.48 billion

As for Thermal Power Plant III increased by 1.2 percent, exceeding MNT 112 billion.

## Sales Manager Index sinks due to slowing Chinese economy

Forward-looking indicators suggest this could be a short term issue.

### ZGM: HIGHLIGHTS

#### POLITICS

Parliament Speaker Zandanshatar Gombojav meets Gabriella Spiri, Director of Cooperation and Consul General at Swiss Agency for Development and Cooperation (SDC). Sides exchanged views on on-going projects and their effects.

Foreign Minister Tsogtbaatar Damdin attends the 4th Meeting of the Silk Road Support Group. Mr. Tsogtbaatar noted that the Silk Road cooperation should be coordinated with China's Belt and Road Initiative and would be proper to invite representatives from China to consult.

#### ECONOMY

The board of UB BUK JSC announces to disburse MNT 131.5 million, MNT 1 per share, in dividends to its shareholders. The dividends will be allocated starting from May 1.

Gutal JSC discloses to administer MNT 777 per share in dividends, in a total amount of MNT 1.2 billion starting from May 6.

Top 20 Index falls 2.26 percent, to 21,393.61 points. MSE A Index sinks 2.41 percent, to 10,021.29 points. MSE B Index rises 1.33 percent, to 8,540.14 points. Market cap stands at MNT 2.54 trillion.

#### SOCIETY

IM Munkhaya Bayartsogt finishes the Standard Chartered Hong Kong Marathon at 6th place, finishing the race in 2 hours 35 minutes and 44 seconds. With this achievement, she has been qualified for the 2019 World Championships in Athletics in Qatar and the Tokyo 2020 Olympics.

# 70 children become victims to cancer every year in Mongolia



Batsaikhan.S / ZGM©

## One out of four children suffering from cancer are dying at early age in Mongolia

Bayarsaikhan.G, Tugsbilig.B  
ZGM

An 18-months old baby was delivered to his second surgery table just recently. Diagnosed with a rare type of cancer that the country is unable to treat, the infant was sent abroad in hopes that better medical

care and equipment would save this brave little heart.

Witnessing the cruelty of the world since birth, this tiny sprout cannot even express the amount of agony he is in. Unfortunately, hundreds of children are suffering from the same illness, struggling to get the better of the excruciating pain. For them, the Pediatric Cancer Hospital of the National Center for Maternal and Child Health (NCMCH) is the only home they know. Some are receiving radiation therapy and some are on surgery beds. It is heart-wrenching to even imagine how much pain they are in.

Up until now, we understood that cancer was an illness for only the elders. But the situation is differ-

ent now. We can see that cancer is a threat to everyone including infants.

At the NCMCH, 60 infants were diagnosed with cancers in 2016. But the number of cancer discovery among newborns increased to 70 last year. Adding the children that are currently being treated, nearly 700 children are suffering from cancer as of today. The number is constantly on the rise without decreasing. As miserable as it is, the country does not have a single study on the cause of this growing number of pediatric cancer.

"The cause of 95 percent of pediatric cancer remain undiscovered. The remaining five percent are due to genetic mutations, in other words

hereditary. The rise in cancer victims is driven by two factors. First, improving diagnosis. We now can discover multiple types of cancer with modern medicine. Secondly, the increasing number of illness that is following the evolution of society," explained a spokesperson of the NCMCH.

The global rate of successful pediatric cancer treatment is currently at 80 percent. But the rate stands at 75 percent for Mongolia. This means that one out of four children are departing this world at the very starting point.

"Although we cannot ascertain the root of the cause, there are assumptions. For example, it could be a numerous virus or the vulner-

ability after a common cold could inflict the tumor. Due to the lack of official studies, we cannot be sure whether if air pollution is another source or not. But it is definitely slowing the process of treatment," said an oncologist at the NCMCH.

It is obvious that there are many factors at play for cancer. But it would not be false to say air pollution is the root of all the potential risks. Troubled by the actual danger among children, another doctor remarked, "I am worried about the newborns. Because they have a very high chance of becoming victims of cancer in just a few years. Although it is not proven scientifically, there is a high chance that this probability could be real." [ZGM]

### SOCIETY


## Consumption of richest group remains 5 times higher than the poorest

As of the end of 2018, the average consumption of the richest 20 percent of the population stands 5.1 times higher than the poorest 20 percent. For instance, the consumption share of the poorest group was 7.7 percent and the richest group was 39.5 percent at the national level.

Household income expanded by around 17 percent in 2018, to MNT 1.1 million. The key driver in the growth was the increase in wage and pension. During this period, the inflation fluctuated between 6 and 8 percent thanks to real income nearly cutting consumer price by half. Additionally, households with an average income of less than MNT 1.1 million accounts for 60 percent of the total number of households.

The average household expenditure had an 11.4 percent growth year over year, to MNT 1.1 million due to the rise in prices of goods

Consumption share by social groups



and services. For example, expenditures on meat and meat products heightened by 18 percent. This was due to the sharp increase in meat exports, creating a supply shortage in the process according to the Ministry of Food, Agriculture, and Light Industry. Plus, the Bank of Mongolia once explained that one of the main drivers in inflation was

the price of fuel.

According to a poverty study conducted by the World Bank Group and National Statistics Office of Mongolia in 2017, one-third of the entire population was struck by poverty in Mongolia. The poverty study is presented biannually; thus, the next edition is expected to be published this year. [ZGM]

### ENERGY

## TPP IV revenue hikes nearly 5 times

Sales revenues of thermal powerplants that supply electricity in the central grid reportedly increased last year. For instance, sales revenue of Thermal Power Plant (TPP) IV grew by MNT 12.5 million and the total revenue jumped by nearly five times, to MNT 4.48 billion.

As for Thermal Power Plant III increased by 1.2 percent, exceeding MNT 112 billion. But the net profits fell by 22 percent, to MNT

8.2 billion. According to the TPP III, the plant has produced 1.08 billion kW/h energy and supplied 905 million kW/h electricity to the domestic power grid, which is 5 percent higher than the initial plan. Throughout the year, a total of 1.3 million tons of coal were used for regular operations in 2018, fully drawing from Baganuur coal mine. As for maintenance, a major overhaul was conducted in the IX turbine.


Tleikhan Almalik, the Chairman and General Commissioner of Energy Regulatory Commission, previously addressed the necessity to increase the capacity of the power grid in Mongolia. Within the frame, four turbines are expected to be upgraded in TPP IV, which will grow the national electricity capacity by 89 MW. Including the smaller projects, about 160 MW power is expected to be installed in the energy sector this year. [ZGM]

### ECONOMIC BAROMETER

## Mongolia's winter chill plus slowing Chinese economy causes growth to falter

Mongolia's economy can now be seen to be suffering from its close links with China. The pullback out of recession now appears to be on the verge of coming to a standstill but forward-looking indicators suggest this could be a short term issue.

- Market and sales indexes fall Sharply;
- Jobs and Business Confidence Indexes continue to signal economic growth
- Domestic economic activity is holding up but China's Slowdown Is Hurting [ZGM]



## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.02.22

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Зорчигчийн үйлчилгээний 1 удаагийн хуванцар бараа бүтээгдэхүүн нийлүүлэх  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** МИАТ/201901002

**МИАТ ТӨХК** эрх бүхий тендерт оролцогчдоос **Зорчигчийн үйлчилгээний нэг удаагийн хуванцар бараа бүтээгдэхүүн** нийлүүлэх тухай 2 багц бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна. Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютээр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн буюу 2017, 2018 оны нийт борлуулалт тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх,
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх,
- Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх,

Тендерийн хамт **Багц 1-д 11,520,000 төгрөгийн, Багц 2-т 2,409,000 төгрөгийн** дүнтэй тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар тендерийн нэг баталгаа гаргаж болох бөгөөд багц тус бүрийн баталгааны дүнг тодорхой бичсэн байх шаардлагатай.

Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 10.30 цаг**-аас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn /-д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг /PKI/-ээр нэвтрэн орж PDF 1 файлаар цахим хэлбэрт шилжүүлэн ирүүлэх ба тендерийг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11.00 цаг -т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодны давуу эрх **тооцохгүй**.

Сонирхсон этгээд тендерийн мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МИАТ ТӨХК. Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45, МИАТ ТӨХК-ийн төв байр**  
**Хангамж, үйлчилгээний хэлтэс 103 тоот**  
**Утас: 70049860, факс: 70049919**



# Өдрийн хэмнэл

## ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00 "Өглөө" хөтөлбөр /шууд/
- 14.30 "Соёл-Эрдэнэ" хөтөлбөр
- 16.45 MNB World: "Мөсөн доорхи шумбалт"
- 18.40 Нээлттэй засаг
- 19.30 Амрыг эрье
- 20.00 "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр

## Bloomberg TV Mongolia

- 07.00 "Суутнуудын намтар" нэвтрүүлэг
- 09.00 "Бизнесийн хэмнэл" мэдээний хөтөлбөр
- 11.00 #Made in Mongolia Баримтат цуврал нэвтрүүлэг
- 18.00 "Бизнесийн төв цэг" Мэдээний хөтөлбөр давталт
- 20.00 "Блумбергийн ярилцах цаг" нэвтрүүлэг
- 22.00 "Инновац-2050" нэвтрүүлэг

## БОЛОВСРОЛ HD

- 09.55 Хөгжмийн завсарлага "Да Винчи ба Митраагийн тайлаглагшгүй нууцууд" ОАК 2.9-р анги
- 14.10 "Аяыг таа" шоу нэвтрүүлэг
- 15.50 "Хөгжмийн цаг"
- 20.40 "Хүрээлэн" амьд ертөнц нэвтрүүлэг
- 01.10 Монголчууд XX зууны эхэнд нэвтрүүлэг
- 12.00 Хөтөч мэдээллийн хөтөлбөр
- 13.30 "Ан амьтдын ертөнцөөр" /season-8/ 19-р хэсэг
- 16.00 "Бид гурвын болзоо" МУСК
- 19.00 "Оргил цаг" мэдээллийн хөтөлбөр
- 21.00 "Чимээгүй номын сан" 13-р хэсэг
- 21.30 "Тэрбумын ертөнц" ОАК 25-р анги

## ЗУРХАЙ



**Билгийн тооллын 18**  
Хаврын тэргүүн улаан бар сарын хоёр хар мэнгэтэй, цагаан бар өдөр  
**Үс засуулбал:** Эд малын гарлагатай  
**Наран ургах, шингэх:** 07.47-18.24  
**Барилдлага:** Үл тохирох  
**Шүтэн барилдлага:** Өтлөх үхэхүй  
**Суудал:** Төмөр

**Аргын тооллын хоёрдугаар сарын 22. Сугар гараг. Билгийн тооллын 18, Тугчин одтой, цагаан бар өдөр.**  
Өдрийн наран 07.47 цагт мандан, 18.24 цагт жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарагаа буцаахад сайн. Золиг гаргах, бумбын үйл, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, хуэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсон баруун урагш мөрөө гаргавал зохистой.

## ОНЦЛОХ ҮЗВЭР

# ТЭНГЭРЭЭС БУУСАН ОД



**Ideee's Special 2019 тоглолт**  
**Хаана:** АСА цирк  
**Хэзээ:** 2019.02.23-ны 20.00 цагт  
**Тасалбарын үнэ:** ₮21400-53500



**"Playing Love 2019" концерт**  
**Хаана:** Corporate Convention Centre  
**Хэзээ:** 2019.03.01, 02-нд 18.45 цагт  
**Тасалбарын үнэ:** ₮30, 50 мянга



**"Хунт нуур" балет**  
**Хаана:** УДБЭТ  
**Хэзээ:** 2019.03.02-ны 17.00 цагт  
**Тасалбарын үнэ:** ₮10-30 мянга

Амжилт бүтээлтэй яваа Гариг хэмээх бизнесмэн залуу өөрийн үзэсгэлэнт эхнэр Од болон найзуудын хамт хөдөөнөөс буцаж явна. Гариг зугаа цэнгэлээ хэтрүүлэн архиныхаа халуунд эхнэрээ замын машины жолоочтой хардан эзгүй хээр орхиж явснаар киноны гол үйл явдал эхэлнэ. Бүсгүй чочролд орж, яахаа мэдэхгүй арай хийн явсаар нэгэн жижиг суманд ирдэг. Нам гүмхэн алслагдсан суманд ирсэн бүсгүйг сумынхан мэл гайхан угтдаг. Тэрбээр санаандгүй байдлаар тус суманд тусламжийн шугамаар гадаадаас ирсэн англи хэлний багш Стивтэй танилцана. Эхнэрээ ор сураггүй алдсан Гариг ганцаараа шаналж, харин хөдөөний хиргүй тунгалаг, сайхан сэтгэлт хүмүүсийн дунд эхнэр нь аз жаргалтай хэд хоногийг өнгөрүүлдэг. Гоо үзэсгэлэнтэй атлаа аадар мэт ааштай Одод Стив сэтгэл алдарч, харин нутаг нугаада ад үзэгдсэн Лут гэдэг залуу түүнийг гартаа оруулна. Хайртай бүсгүйнхээ хойноос Гариг, Стив нар хамт тэмцдэг "Хувьсал" продакшны энэ бүтээл гуравдугаар сарын 1-нээс дэлгэцнээ гарч эхэлнэ. [ЗГМ]



**"Бүсгүй танаа" концерт**  
**Хаана:** Соёлын төв өргөө  
**Хэзээ:** 2019.03.07-ны 19.00 цагт  
**Тасалбарын үнэ:** ₮ 15-25 мянга



**"Хайр гэж" live concert**  
**Хэзээ:** 2018.03.08-ны 19.00 цагт  
**Хаана:** Corporate Convention Centre  
**Тасалбарын үнэ:** ₮60-100 мянга




**"Дон Кихот" бүжгэн жүжиг**  
**Хэзээ:** 2018.03.17-ны 17.00 цагт  
**Хаана:** УДБЭТ  
**Тасалбарын үнэ:** ₮10-20 мянга

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

11.22	11.23	11.24	11.25	11.26
1° -15°   6 м/с 4 м/с	-3° -16°   8 м/с 6 м/с	-5° -18°   6 м/с 4 м/с	-3° -18°   6 м/с 4 м/с	-2° -16°   6 м/с 5 м/с
Багавтар үүлтэй	Үүлшинэ	Багавтар үүлтэй	Үүлшинэ	Үүлшинэ



## ФОТО АГШИН



Амь тэнссэн аялал

Б.Хасуй / ЗГМФ

## ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1	2	3	4	5		
6	7	8	9	10		
		11				
12	13		14	15	16	
		17				
18						19

### БОСООГООР.

- 2. Мэргэжлийн сагсан бөмбөгийн хамгийн том холбоо
- 3. Монгол циркийн шинэ нэр
- 4. Дэлхийн хамгийн урт могой (хорт)
- 5. Эртний хүчирхэг гүрэн
- 6. Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг дахь "Баруун хүрээ" хэмээн алдаршсан хийд
- 7. Италийн

### ХӨНДЛӨНГӨӨР:

- 1. Төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч
- 6. "Их Монгол" хэмээн алдаршсан даншигийн телевиз
- 11. Өвлийн спортын төрөл
- 12. Удаан, нөр
- 13. 1970-аад оны Шведийн алдарт хамтлаг
- 15. Гарын нэг хэсэг
- 16. Усанд ургадаг ургамал

### аварга

- 11. Мойл жимсний мод
- 12. ... толгод
- 14. Адар
- 17. Өмнөговь аймгийн нутаг, дэлхийд үлэг гүрвэлийн үүр

### олдсон анхны газар

- 18. Зэллэж ургадаг жимст ургамлын нийтлэг нэр
- 19. Дуу хөгжмийн ерөнхий ая

Г	Р	А	Г	Ч	А	Г	У	У	А	М	А	Л	Х		
Г	А	В	А	Р	Г	А	Г	А	А	Б	У	Л	А	А	М
Л	В	Ү	Ү	Э	Н	Х	Р	М	О						
Б	И	Т	Ү	Ү	Р	О	А	Г	А	А	Р				
А	О	Р	Ч	И	В	М	Р	Ь							

Өмнөх дугаарын хариу / 02.21

## ЗГМ: СУДОКУ

				1			9
5	4		6	1			
9			7				8
		2	6				
				8			
8				5	7	3	
	3		2				
		6	9				
	6	5				3	

6	5	8	2	4	7	1	3	9
4	7	3	6	1	9	2	8	5
1	2	9	3	8	5	6	4	7
3	4	5	7	9	2	8	1	6
9	6	7	1	3	8	5	2	4
2	8	1	4	5	6	7	9	3
8	3	2	5	6	4	9	7	1
7	1	6	9	2	3	4	5	8
5	9	4	8	7	1	3	6	2

(Анхны дугаарын хариу)



## ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРЭЭН	20.00	10.25
УБ-БЭЭЖИН	07.15	14.04
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



## НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-БЕРЛИН	13.20	16.05
УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ӨЛГИЙ	15.05	16.00
ӨЛГИЙ-УБ	16.30	19.20
УБ-УЛААНГОМ	20.00	20.40
УЛААНГОМ-УБ	21.10	23.50



# ЭДИЙН ЗАСАГ



## Galaxy S10 VS iPhone XS Max

Samsung-ын загвар дижитал контент хадгалах багтаамжаараа аваргын титмийг авлаа.

>10

## Хятад баячууд татвараас бултахад хэцүү боллоо

Санхүүгийн мэдээллийг ил тод болгоход чиглэсэн шинэ тогтолцоо мөнгөө гадаад байршуулагчдыг “хазаж” эхлэв.

>10



# Бодлого тодорхойлогчид хүү өсгөх асуудлыг бүрхэг үлдээв

### Кристофер Кондон, Крэйг Торрес

Төв банкны тайлан тэнцлийг багасгах ажиллагааг зогсоохоор АНУ-ын Холбооны Нөөцийн Системийн удирдлага санал нэгдсэн ч бодлогын хүү өсгөх асуудал бүрхэг хэвээр үлдэв. Үүнийг тус байгууллагын нэгдүгээр сарын хуралдааны тэмдэглэл нотолно.

“Холбооны нөөцийн актив багасгах ажиллагааг зогсоохоо яаралтай зарлах нь зүйтэйг ихэнх оролдогч зөвшөөрсөн” гэж Холбооны Нээлттэй Зах Зээлийн Хорооны (FOMC) хуралдааны тэмдэглэлд дурджээ. Тэмдэглэлийг хоёрдугаар сарын 20-нд нийтэлсэн юм.

“Төлөвлөгөөг зарлангуут Холбооны Нөөцийн Системийн тайлан тэнцлийн хэмжээг хэвийн болгох ажиллагаа дууссан нь тодорхой болно” хэмээжээ. Ийн тэмдэглэсэн нь 2017 оны эцсээс эхэлсэн тайлан тэнцлээс актив хасах ажиллагааг хэлж буй хэрэг юм. Санхүүгийн хямралын үеэр эдийн засгаа хамгаалах онцгой арга хэмжээ болгон өсгөснөөр 2015 онд оргилдоо тулж 4.5 их наяд ам.долларт хүрсэн тайлан тэнцэл багассаар эдүгээ дөрвөн их наяд ам.доллар болоод байна.

“Байнгын аварга тайлан тэнцэл болно” хэмээн Jefferies LLC-гийн эдийн засагч Уорлд МакКарти тодорхойлов. Тэрбээр “Хямралын

өмнөх үеийнхтэй харьцуулахад тайлан тэнцэл илүү томрох ёстой гэгцээдэг. Гэтэл одоогийн байдлаар харин ч багасах нь” гэв.

Бодлогын хүү өсгөхөө түр азнаж, багассаар байгаа тайлан тэнцэлд илүү уян хатан хандах бэлтгэл хийж байгаагаа Холбооны Нээлттэй Зах Зээлийн Хороо гурван долоо хоногийн өмнө мэдэгдсэн. Ерөнхийлөгч Дональд Трамп төв банкны удирдлагыг мөнгөний бодлогоо хэт чангаллаа хэмээн аашилж АНУ, БНХАУ-ын худалдааны зөрчил хурцдан, АНУ-ын үнэт цаасны зах зээл 12 дугаар сард 1930-аад оноос хойш тохиолдож байгаагүйгээр муудсаны дараа

бодлого өөрчлөгдөж байна.

Тодорхойгүй байдлыг багасгахын тулд Нээлттэй зах зээлийн хороо мөнгөний “хүлээцтэй” бодлогыг шинээр тодорхойлж, өөр мэдэгдэл гаргах ёстой хэмээн үзэж байгааг тэмдэглэлд тайлбарлажээ.

Холбооны Нээлттэй Зах Зээлийн Хорооны тэмдэглэл нийтлэгдсэний дараа АНУ-ын үнэт цаасны үнэ үл ялиг өсөж, S&P 500 индекст 0.2 хувиар сайжрав. АНУ-ын Сангийн яамны 10 жилийн хугацаатай бондын өгөөж өсөж 2.64 болсны зэрэгцээ ам.доллар ханш унасан ханшаа сэргээлээ. Холбооны сангийн фьючерс бодлого

тодорхойлогчдын 12 дугаар сарын уулзалтын үеийнхээс үл ялиг бага буюу гурван суурь нэгжээр буурав.

Төв банк хүүгээ шат дараатай өсгөх бодлогоос ухарсаар байгаа ч Холбооны нөөцийн хүүг зохистой хэмжээнд баруулах өөрчлөлт одоо ч тодорхойгүй тул оны эцсээс нааш дахиад өсөхгүй хэмээн зарим нь таамаглаж байна. “Инфляц тооцоолсноос илүү ихсэх тохиолдолд” хүү өсөх магадлалтай хэмээн нэг хэсэг нь үзэж байна. Гэтэл эдийн засаг тооцоолсноор урагшилвал оны эцэс гэхэд бодлогын хүүг өсгөнө хэмээн өөр зарим нь тайлбарласныг тэмдэглэлд

дурджээ.

БНХАУ, Европ тивд эдийн засаг удааширсан, Brexit, худалдааны сөргөлдөөн, АНУ-ын Засгийн газрын ажиллагаа тасалдсан зэрэг болон эрсдэлтэй нөхцөлд бодлогоо хэзээ, хэрхэн өөрчлөх эсэхэд Холбооны Нөөцийн Систем “хүлээцтэй” хандана хэмээн тус байгууллагын тэргүүн Жером Пауэлл нэгдүгээр сарын 30-ны хэвлэлийн хурлын үеэр мэдэгдсэн.

Холбооны Нээлттэй Зах Зээлийн Хороо бечмарк бодлогын хүүгээ 2.25-2.5 хувийн хооронд өөрчлөлгүй хэвээр үлдээхээр чимээгүйхэн шийдвэрлэсэн юм.

## Стив Жобсын өрсөлдөгч дахин хүчээ авлаа

### Ли Ю-Лин

Хорвоо ертөнц Стив Жобсын араас эмгэнэсээр байсан 2011 оны аравдугаар сарын 11-нд нэгэн хүн Сингапурын сонины бүтэн нүүрийг 16 мянган ам.доллараар худалдан авч, Apple Inc-ийг үндэслэгчид хүндэтгэл үзүүцсэн. Уг дурсгалын нүүрэнд “Агуу сургамжид тань, агуу бүтээгдэхүүнүүдэд тань гялайлаа. Бид бүхнийг цоо шинэ ертөнцөд хөтөлсөнд тань гялайлаа” гэсэн мөр дургайж байв. Гарын үсэгтэй хэсэгт “Сим Вон Ху, Creative Technology Ltd-ийн тэргүүн, гүйцэтгэх захирал” гэсэн байгаа.

Тэр өдрийн дугаар уншигчдад чухам сонирхолтой байсан юм. Сим бол 400 сая ширхэг персонал компьютерт дуу авиа оруулж буй Sound Blaster картаараа Сингапурыг дэлхийд таниулагч нэгэн. Тэрбээр дуу хөгжим тоглуулдаг авсаархан тоглуулагч-плейерээс болж Жобстой дайтсан хүн. Дайсагнал гаарсаар 2006 онд Сим Apple компанийг iPod-д патентын эрх зөрчсөн хэмээн шүүхэд өгчээ. Америк өрсөлдөгч ярианд давамгайлснаас үүдэн Жобстой учраа ололдох хэцүү байсныг Сим дурсав. Сим эцэст нь Apple-аас 100 сая ам.доллар салгаж салав. Тухайн үед Жобс хэлэхдээ “түрүүлж патент эзэмшсэн Creative тун азтай” хэмээж байв.

Хожим хоёр компанийн хувь тавилан эргэсэн билээ. Америк үйлдвэрлэгчийн iPod хувьсалт бүтээгдэхүүн болж, Симийн MP3 тоглуулагчийг бут

ниргэв. Creative-ын од ч бөхлөө. Сингапурын биржид 2000 оны гуравдугаар сард үнэмлэхүй өсөж, 65 сингапур доллар (47 ам.доллар) хүрсэн Creative-ын хувьцааны үнэ 2017 онд ердөө нэг сингапур доллар орчимд эргэлдэх болов. Тус компани бүр 2007 онд NASDAQ-аас хувьцаагаа сайн дураараа татсан юм.

Олон жилийн дараа 100 сая ам.долларын хөрөнгө оруулалт, Super X-Fi шинэ аудио технологитойгоор Сим эргэн ирж байна. Super X-Fi тоглоомын дүрмийг өөрчилнө хэмээн Сим үзэж буй. Чихэвчин дотор юм уу, тусдаа аудио өсгөгч хэлбэрээр

ажилладаг энэхүү технологийн ачаар дуу хөгжмийн хөг аялгуу энгийн чихэвчинээс бус, олон чанга яригчаас гарч байгаа юм шиг сонсогдож, Creative ийм дуу авиаг “голограф аудио” хэмээн нэрлэж байна. Шинэ технологийг ашиглах хэрэглэгч Super X-Fi аппликэйшн ашиглан нүүр, чихнийхээ зураг авна. Программ хангамж авсан зурагтад тулгуурлан тухайн хэрэглэгчийн чихэнд нийцүүлсэн сонсогдох орчин үүсгэж өгнө.

Энэхүү технологийг хөгжүүлэхийн тулд Creative компани мянга мянган хүний дуу авиа хүлээн авч сонсох нөхцөлийг

нэг бүрчлэн судалж, студи дотор чихэнд нь микрофон байршуулан хэмжиж үзсэн байна. Хэмжилтийн дүнг хиймэл оюун ухаанд дамжуулж, хүмүүст дуу авиа хэрхэн сонсогдож байгааг тооцоолжээ.

Жижиглэн худалдаанд Creative-ийн SXFI AMP чихэвчний өсгөгч 150 ам.доллар, SXFI AIR Bluetooth чихэвч 160 ам.долларын үнэтэй. “Амьдралдаа дуу авиаг ийм сайхан сонсож байсангүй” хэмээн эдүгээ 63 настай Сим ярьж байлаа. Super S-Fi технологи нь Лас Вегаст Best of CES 2018 шагнал хүртэж, аналитууд магтаал дүүрэн үнэлгээ өгсөнтэй уялдан Creative-ийн хувьцааны үнэ хоёрдугаар сарын 22-ноос гуравдугаар сарын 5-ны хооронд долоо дахин өсжээ.

Хожим үнэ буурсан ч компанийн үнэлгээ 365 сая орчим сингапур долларт тогтвортой байгаа. Урьд нь ердөө 2017 онд Creative 80 сая сингапур долларын үнэлгээтэй байв. “Шинэ хувьсалт бүтээгдэхүүн болж чадна” хэмээн United First Partners-ын судлаач Жастин Дан үнэлсэн юм. Creative технологийн лицензээ ухаалаг утас үйлдвэрлэгч, видео тоглоомын компани, автомашин үйлдвэрлэгчдэд хүртэл борлуулан мөнгө олох боломжтой. Ирэх хоёр жилд үнэгүй хэрэглэгчдийг оролцуулаад Super X-Fi-ийн 50 сая үйлчлүүлэгчтэй болохоор Сим тооцоолж байна.

## LYFT КОМПАНИ IPO ГАРГАХААР ТӨЛӨВЛӨЖ БАЙНА



Lyft компани IPO гаргаж, 20-25 тэрбум орчим ам.долларын хөрөнгө төвлөрүүлэхээр төлөвлөж байна.

Унаа дуудах үйлчилгээний хоёр дахь гол компани гуравдугаар сарын 18-наас хувьцаагаа анх удаа нээлттэй арилжихаар төвлөснийг эх сурвалж уламжиллаа. Уг төлөвлөгөө нь Lyft компанийг зах зээлийн гол өрсөлдөгч Uber Technologies-ээс түрүүлж нээлттэй хувьцаат компани болгох юм.

## ФРАНЦЫН ШАВЖ ҮРЖҮҮЛЭГЧ \$125 САЯЙГ КОМПАНИ ТАТАВ



### Мария Мавад

Венчур капиталд хөрөнгө оруулагч нар роботууд хариуцаж ажилладаг, өт үржүүлгийн дэлхийн хамгийн аварга фермд 125 сая ам.долларын хөрөнгө орууллаа. Ynsect start-up өтийг хүний хоолонд зориулж үржүүлдэггүй. Эдгээр өт нь загас, мал амьтныг тэжээл болгон, бордооны үйлдвэрт нийлүүлэх гурилын цохны авгалдай юм. Бүрэн автомат ажиллагаатай шинэ ферм нь жилдээ шавжнаас гаралтай 20 мянга гаруй тонн уурагт тэжээл үйлдвэрлэнэ.





## Эдийн засаг

# Galaxy S10 VS iPhone XS Max

### Нэйт Лэнксон

Samsung шинэ загварын гар утсаа өрсөлдөгч Apple-ийн шинэ бүтээгдэхүүнээс хэдхэн сарын дараа зах зээлд танилцуулав. Аль нь илүү вэ?

Samsung Galaxy S10 нь дотроо S10e (essentiial), S10, S10+, S10 5G гэсэн дөрвөн өөр загвартай. Гуравдугаар сараас худалдаанд гарах эхний гурав дотроо S10+ нь шилдэг.

Гурван өөр дивайсаас бүрддэг нэг бүл тренд болсон өнөө цагт S10e, S10, S10+ нь Apple-ын iPhone XR, XS, XS Max-д барьж буй Samsung-ын хариу юм. Galaxy “S ten”, iPhone “ten S” гэх мэт нэршил ижил төстэй ч хоёр үйлдвэрлэгчээс хэрэглэгчийн хэтэвчний араас хөөцөлдөх өрсөлдөөнд ноцтой зарим ялгаа бий.

### ХИЙЦ ДИЗАЙН, ЗУРГИЙН ЧАНАР

Дээд ангиллын утсанд гэрэл зургийн чанар чухал ач холбогдолтой. Samsung компани S10+ загвараа ар талын гурван камертай хийжээ. Нэг нь ойрын зайн стандарт зураг авах зориулалттай бол нөгөөх нь арай том өргөн өнцгийн зураг дарахад тохиромжтой. Харин iPhone хоёрхон арын камертай нь дутагдал юм шиг санагдаж болох. Хэрэг дээрээ камерын линз зургийн чанарыг тэр бүр тодорхойлж чаддаггүй. Тэгээд ч Apple техник үзүүлэлтэд “гооноос чанарыг эрхэмлэдэг”. Юутай ч гурван линз нь креатив нэгэнд хоёроос илүү боломж.

S10+ лут 6.4 инчийн дэлгэцтэй бол iPhone XS Max-ынх үл ялиг том 6.5 инч. Нүүрэн талын камерыг дэлгэцнээ хэрчлээс гаргаж байрлуулсан, сүүлийн үед стандарт болоод буй iPhone шийдлийг Samsung ашигласангүй. S10+ загварын нүүрэн талын камер



урьд нь тохиолдож байгаагүй, “нүхлэсэн” байрлалтай. Ийм шийдэл дэлгэцийг тэгш хэмгүй болгосон ч ашигтай талбайг нь ихэсгэж өгчээ.

Apple утасныхаа дэлгэцэнд том хэрчлээс гаргасны учир

нь дивайсын аюулгүй байдал, нууцлалын төлөө дотор талд царай таних дэвшилтэт төхөөрөмж суурилуулсных. Хэвийн ажиллахын тулд хэд хэдэн сенсор шаарддаг FaceID технологи нь дэлгэцийн зарим

хэсгийг зогилт гаргахаас аргагүй болгож байгаа юм.

Samsung аюулгүй байдлыг орхиогүй. Гэхдээ тус компанийн хурууны хээ уншигч дэлгэцийнхээ шууд ард байрладаг. Хэрэглэгчийн хурууг танихдаа

хэт авиа ашигладаг ийм уншигч уламжлалт сенсороос илүү найдвартай хэмээн Samsung тайлбарлаж байна.

Учир ойлгомжтой: Хурууны хээ уншигч ашиглаж дэлгэцийн ашигтай талбайг ахиу үлдээх үү,

царайгаа таниулахын төлөө хэсэг пикселийг үгүй хийх үү гэдгээ сонго.

### ЧАДВАР, ХҮРД ХҮЧ

Galaxy S10+, iPhone XS Max аль аль нь утасгүй цэнэглэх чадвартай. Гэвч Samsung-ынх өөр бусад дивайсыг алсаас цэнэглэдэг бонустай. Онолын хувьд хэрэглэгч S10+ утсаа дээр нь байрлуулж байгаад найзынхаа iPhone-ыг цэнэглэж өгч болно гэсэн үг. Гэхдээ Samsung компани уг функцийг чихэвч, ухаалаг утас гэх мэт аксессуар цэнэглэхэд ашиглахыг зөвлөж байна.

Samsung-ын загвар дижитал контент хадгалах багтаамжаараа аваргын титмийг авлаа. S10+ загварын дотоод багтаамж нэг терабайт буюу iPhone XS Max-ын их багтаамжтай хувилбараас хоёр дахин их. Дээр нь S10+ загвар 512 ГБ хүртэл багтаамжтай SD карт дэмждэг тул нийт багтаамжийг нь Apple-ын манлай загварынхаас гурав дахин ихэсгэх бололцоотой.

Дөнгөж зарлаад буй Samsung-ын шинэ загварын ажиллагааны хурдыг одоогоор iPhone-той харьцуулах аргагүй. Apple-ын загвар өөрийнх нь бүтээл болох зургаан тооцоолох цөм бүхий A12 Bionic чиптэй бол Samsung-ынх найман тооцоолох цөмтэй. Гэхдээ iOS үйлдлийн системтэй нягт интеграцчилгдсан. Apple-ын тусгай хийц бүхий цахиур чип ихэнхдээ цаасан дээр сүүртэй харагддаг өрсөлдөгчдийнхөө процессороос давуу ч байж болно.

### ДҮГНЭЛТ

Юутай ч өрсөлдөгчдийн манлай загвар аль аль нь хэрэглэгчээс даалгах ямар ч ажлыг нугалж чадна. Алийг нь ч худалдаж авсан манай гарагийн хамгийн хүчирхэг утасны нэгийг авч буй хэрэг.

## Хятад баячууд татвараас бултахад хэцүү боллоо



### Том Меткаф

Татвараас булгасдыг дарах Бээжингийн арга хэмжээтэй уялдан баян чинээлэг хятадууд эх орондоо төдийгүй хилийн чанадад ч татварын тоо томшгүй зохицуулалттай тулгарах болов.

Төрийн мэдээллийн хэрэгслүүд татварын хууль дүрэмд орсон өөрчлөлт, татвараас булгасдыг нэр заан шившиглэх засгийн газрын арга хэмжээг өрсөлдөн зарладаг боллоо. Олны танил хүмүүсийн нэр ч захаасаа гарч эхлэв. Олон сар үргэлжилсэн шалгалтын эцэст Хятадын хамгийн их орлоготой кино од Фань Бинбин торгуулийн хамт нийт 100 сая гаруй ам.долларын төлөөгүй татвараа нөхөн төлөх үүрэг хүлээсэн нь дотоодын кино үйлдвэрлэлийг доргиолоо.

CRS (Common Reporting Standard) буюу нийтлэг тайлагнах стандарт хэмээх нэртэй, санхүүгийн мэдээллийг ил тод болгоход чиглэсэн, дэлхийн нийтээр мөрдөн дагах шинэ тогтолцоо мөнгөө гадаадад байршуулагчдыг “хазаж” эхэллээ. БНХАУ нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гишүүн улсад татвар төлөх үүрэгтэй хүмүүсийн дансны мэдээллийг 2018 оноос хойш дэлхийн

100 орчим улс, тусгай бүстэй автоматаар солилцдог болсон юм.

Татвараас зайлсхийгчдыг нухчин дарах ажиллагаа дундад улсын хувийн эд баялаг шинэ амжилт тогтоосон үетэй давхцаж байна. БНХАУ-д 2018 онд хэд


хоноод л нэг тэрбумтан шинээр төрж байсныг UBS Group AG-ын судалгаа харуулав. Boston Consulting Group-ийн судалгаагаар Хятадын хувийн эд баялаг үнэмлэхүй буюу 24 их наяд ам.долларт хүрээд байгаагийн нэг их наяд нь гадаадад байрладаг.

### Татвараас бултах нь хэцүү болсоор

2018 оны 11 дүгээр сарын байдлаар

2020 он гэхэд дэлхийн 100 орчим улс, бүс нутаг татварын мэдээлэл солилцдог болно.

- 2017-2018 оноос мэдээлэл солилцож эхэлсэн
- 2019-2020 оноос мэдээлэл солилцох эхлэх
- Үүрэг хүлээсэн ч тов тодорхойгүй
- Үүрэг хүлээгээгүй



Зохицуулалтад нэгдээгүй АНУ өөрийн “Гадаад данснаас татвар авах хууль”-аа баримтална.

ЭЗХАХБ (OECD) ©

Үүссэн нөхцөл нь гадаадад данс эзэмшигчид, үйлчлүүлэгчийнхээ төлөх татварыг багасгах ухаан сийлэгч активын менежерүүдийн арми, тэднийг сөрөгч дэлхийн улс орны засгийн газар, зохицуулах байгууллагуудын хооронд муур,

хулганын тоглоом, ялангуяа Хятадад ширүүссэнийг харуулав. “CRS хэрэгжиж эхэлсний дараа асар баян хүмүүс түгшиж бухимдах болсон”-ыг БНХАУ-ын татварын албаны мэргэжилтэн байсан Лю Шуан тайлбарласан юм. Хожим Бээжинд хөрөнгийн

татварын менежментийн компани байгуулсан түүнээс зөвлөгөө авагчид жилийн дотор эрс өсжээ. “Төлөөгүй татвартаа түгшихийн зэрэгцээ гадаад дахь хөрөнгө нь илрэхээс бүгд айцгааж байгаа”-г Лю Шуан өгүүлэв.



## Эдийн засаг

### БАНК САНХҮҮ

**Аль ч улс зээлийн хүүг хязгаарлахдаа туйлын болгоомжтой ханддаг**

Г.Байгал  
@baigalZGM

Макро эдийн засгийн тусгал болох зээлийн хүүг албадлагын шинжтэй арга хэрэгслээр хязгаарлах нь зүйтэй гэж зарим улстөрч үзэж буй. Тэгвэл зах зээлийн зарчмаар тогтсон бодит хүүг хүчээр хөндөх нь оновчтой эсэхийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүн, эдийн засагч Ч.Хашчулуунаас тодрууллаа.



С.Батсайхан / ЗГМӨ


Зах зээлийн зарчмаар тогтсон санхүүжилтийн өртгийг албадлагын аргаар хязгаарласан тохиолдолд банк эсвэл санхүүгийн ямар нэгэн байгууллага зээл олгохоо зогсоох эрсдэлтэй.

# Зээлийн хүүг хүчээр тогтоох нь иргэдийг мөнгө хүүлэл рүү түлхэнэ

-Зээлийн хүүд дээд хязгаар тогтоох санал олон нийтийн анхаарлыг татсаар байна. Хүүгийн хувь хэмжээг хөндөх нь санхүүгийн салбар төдийгүй энгийн иргэд, макро эдийн засагт ямар нөлөөтэй вэ?

-Зээлийн хүүг ярихын тулд эхлээд зээл гэж юу болохыг тайлбарлах хэрэгтэй. Зээл бол санхүүгийн үйл ажиллагааны чухал хэсэг. Аль ч улс зээлийн хүүг хязгаарлахдаа туйлын болгоомжтой ханддаг. Бид зээлийн хүүг хүчээр тогтоолоо гэхэд дээд хязгаарыг нь зөв оношилж, тооцож чадах уу гэдэг асуулт урган гарна. Япон, Солонгос зэрэг улс иргэдээ сүүдрийн зах зээл гэгддэг мөнгө хүүлэгчдээс хамгаалахын тулд зээлийн хүүд дээд хязгаар тогтоодог. Харин банк бол мөнгө хүлээгчдээс өөр, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Хэдийгээр бид арилжааны банкуудын зээлийн хүүг өндөр гэж шүүмжилдэг ч Монголын санхүүгийн зах зээл дэх хамгийн хямд хүүг одоогоор арилжааны банкууд л санал болгож байна. Учир нь банкны систем нь хууль эрхзүйн орчинд бий болсон, төв банкны зохицуулалт дор үйл ажиллагаа явуулдаг. Төв банк ч ард иргэдээ зээлийн хүүгийн дарамтад унагахгүйн тулд хүүг бууруулах чиглэлээр анхаарч ажилладаг. Тухайлбал, Монголбанк зээлийн хүүг бууруулах үндэсний стратегийн баримт бичиг боловсруулсан бөгөөд мөрдлөг болгодог.

-Зээлийн албан тогтолцооны далд зах зээлээс ялгарах давуу



тал нь юу вэ?

-Банкны системд зээлийн албан буюу хуулийн зохицуулсан тогтолцоо үйлчилдэг учраас мөнгө зээлсэн иргэд ямар ч тохиолдолд хуулийн хамгаалалтад байдаг. Гэтэл зах зээлийн зарчмаар бий болсон санхүүжилтийн өртгийг албадлагын аргаар хязгаарласан тохиолдолд банк эсвэл санхүүгийн ямар нэгэн байгууллага зээл олгохоо зогсоох эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, санхүүжилтийн хүртээмж хумигдана. Яагаад гэвэл, зээлийн хүүгийн хувь хэмжээ нь хүчээр барьчихсан санхүүгийн системд зээл олгох нь банкинд ашиггүй болж, цаашлаад дампуурна.

Ингэснээр зээл олгох чадваргүй болж, банкинд итгэж

мөнгө хадгалуулсан иргэд хохирно. Санхүүгийн тогтолцоонд арилжааны банкууд чухал үүрэгтэй. Тэднийг буруутгаж, чичиллээ гээд эдийн засаг өөдлөн дэвжихгүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин ч маш их хохирол амсана.

Зээлийн эрэлт, хэрэгцээ хэзээд зах зээлд бий болно. Энэ эрэлт хэрэгцээг таслан зогсоох боломжгүй. Гэтэл эрэлт, нийлүүлэлтийн хүрээнд бий болсон энэ зах зээлийн аль нэг хэсэгт нь хязгаарлалт тогтоочихоор бүх юм өргөс авсан мэт алга болчихгүй. Харин ч зээл авах хүсэлтэй иргэдийг албан бус буюу мөнгө хүүлэл рүү түлхэхэд хүрнэ. Тиймээс зээлийн хүүг аль болох зах зээлийн жамаар нь тогтоох хэрэгтэй.

-Банкууд зээлийн хүүг өндөр тогтоож байна гэж энгийн иргэдээс эхлээд улстөрчид хүртэл шүүмжлэх боллоо. Банкууд зээлийг хүүг өсгөж байна уу?

-Зээл өгч буй мөнгө бол банкны хөрөнгө биш. Арилжааны банкуудад дүрмийн сан бий. Гэхдээ энэ сангийн хөрөнгө хязгаарлагдмал. Иргэдэд зээл хэлбэрээр олгож буй мөнгө нь хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэж, хадгалуулсан хөрөнгө. Зээл авч буй иргэд бага хүүг хүсдэг бол мөнгөө хадгалуулсан хүмүүс аль болох өндөр хүүг илүүд үзэх нь ойлгомжтой. Энэ хоёр талын огтлолцлыг банк тэнцвэржүүлэх үүрэгтэй. Харин өөрөө мөнгөтэй эсвэл мөнгө хэвлээд, түүнийгээ иргэдэд өндөр хүүтэй зээл олгодог байгууллага биш. Тиймээс зээлийн хүүд хадгаламжийн хүү нөлөөлдөг. Үүн дээр банкуудын барилгын түрээс, зардал ажилчдын цалин зэрэг үйл ажиллагааны зардал нэмэгдэнэ. Тиймээс хадгаламжийн хүүг бууруулахгүйгээр зээлийн хүүг багасгах боломжгүй.

● **Бодлого буруу, эрсдэл өндөр, манай шүүхийн байгууллага сайн ажиллахгүй байгааг зөвхөн банкуудтай холбож болохгүй.**

● **Хязгаарлагдмал хадгаламжид их хэмжээний эрэлт үүссэнээс хадгаламжийн хүү ч, зээлийн өртөг ч өндөр байгаа юм.**

● **Зээлийн хүүгийн хувь хэмжээг нь хүчээр барьчихсан санхүүгийн системд зээл олгох нь банкинд ашиггүй болж, цаашлаад дампуурна.**

Монгол Улс хүн ам цөөтэй. Үүнээс хадгаламжтай иргэд бүр цөөхөн. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний хөрөнгө буюу хязгаарлагдмал хадгаламжид их хэмжээний эрэлт үүссэнээс хадгаламжийн хүү ч, зээлийн өртөг ч өндөр байгаа юм. Хадгаламжийн хүүг бууруулахын тулд төр тодорхой алхам хийж болно. Тухайлбал, хадгаламжийн эрсдэлийг бууруулснаар хүү нь багасна. Үүний тулд хадгалуулсан хөрөнгө нь хадгаламж эзэмшигчдэд эргээд 100 хувь очно гэсэн баталгааг бий болгох хэрэгтэй.

-Хууль шүүхийн маргаан банкуудын үйл ажиллагааны зардалаар дамжин зээлийн хүүг

өсгөдөг гэж мэргэжлийнхэн хэлдэг. Зээлээ цаг хугацаанд нь төлөөгүй иргэдээс үүдсэн энэ төрлийн зардлыг бууруулах боломж бий юу?

-Зээл бол банкны өөрийн хөрөнгө бус хадгаламж эзэмшигчийн мөнгө гэдгийг өмнө нь хэлсэн. Харин банк гэдэг хадгаламж эзэмшигчийн мөнгөөр менежмент хийж буй байгууллага. Тиймээс банк зээл олгосон мөнгөө буцаагаад иргэдээс авч, хадгаламж эзэмшигчдэд олгох үүрэгтэй. Гэтэл зээлээ төлөлгүй гүрийд зарим иргэнээс хадгаламж эзэмшигчдийн мөнгийг хууль шүүхийн дагуу авахын тулд банк багагүй хугацаа болон зардал гаргаж байгаа. Дунджаар хоёр хүртэл жил зарцуулдаг гэх тооцоо бий. Энэ хэрээр зардал өснө.

Зээлээ хугацаанд нь төлдөггүй иргэд өсөхийн хэрээр зээлийн хүүг өсгөхөөс аргагүй болж байгаа юм. Ингэснээр дүрэм журам сахидаггүй иргэдийн өмнөөс шударга жирийн иргэд хохирно. Тиймээс төр зээлийн маргааныг дунд шатны буюу хууль, шүүхийн хүрээнд шийдэх хугацааг багасгах хэрэгтэй. Банкны систем дэх эргэн төлөлтийг дэмжиж, эрсдэлийг бууруулахгүйгээр зээлийн хүүгээ багасгах хэмээн банкуудаас шаардах нь шударга бус.

-Арилжааны банкуудыг чичлэх, буруутгах хандлага иргэд төдийгүй улстөрч, эдийн засагчдад ажиглагддаг. Монголын санхүүгийн салбарын 90 гаруй хувийг нуруун дээрээ үүрдэг энэ системийн эрсдэл нэмэгдсэнээр ямар үр дагавар бий болох вэ?

-Банкны тогтолцоо нь аливаа улсын санхүүгийн системийн суурь болдог. Энэ систем дэлхийд 700-800 жилийн өмнө үүссэн баялаг түүх, уламжлалтай, өөрийн гэсэн хууль журамтай. Монголын банкны систем ч ялгаагүй. Манай улс 1920-иод оноос тусгаар тогтносон улсын байр сууринаас банкны системийг хөгжүүлж байна. Банкны тогтолцоо нь хадгаламж эзэмшигчдээс мөнгө татан төвлөрүүлээд, мөнгө хэрэгтэй иргэдэд зээл олгох дамжуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Гэтэл дамжуулагчаа хүүлэл хийж байна хэмээн буруутгах нь утгагүй. Зээлийн хүү нь хадгаламжийн хүүгээс үүсэж байгаа. Бодлого буруу, эрсдэл өндөр, манай шүүхийн байгууллага сайн ажиллахгүй байгааг зөвхөн банкуудтай холбож болохгүй. Харин банкны тогтолцооны зардлыг бууруулахад анхаарч хэрэгтэй. Үүний тулд хууль шүүхийн орчныг шинэчлэх зэрэг шат дараатай олон ажил хийх ёстой. Гэтэл энэ чиглэлд дорвитой алхам хийхгүй атлаа банкуудыг шүүмжлэх нь шударга бус. [ЗГМ]

### БИЗНЕСИЙН ОРЧИН

## Борлуулалтын менежерүүдийн индекс уналтын бүсэд шилжив

Монгол Улсын борлуулалтын менежерүүдийн индекс хоёрдугаар сард 49.9 нэгж буюу уналтын бүсэд шилжснийг World Economics байгууллага мэдээллээ. Ингэснээр сүүлийн нэг жилийн доод цэгт хүрэв. Тус индекс ийн уналтын бүсэд шилжихэд зах зээлийн нөхцөл байдал болон борлуулалт саарсан нь нөлөөлжээ. Тухайлбал, борлуулалтын өсөлт хоёрдугаар сард саарч, 36 нэгж болсон нь 2016 оны арваннэгдүгээр сараас хойших доод түвшин аж. Үүнд БНХАУ-ын эдийн засгийн удаашрал болон



улирлын чанартай шалтгаан нөлөөлсөн гэж тус байгууллага үзжээ. Монголын бизнесийн итгэлийн индекс болон ажлын байрны индекс эдийн засаг өсөх

дохиог харуулж байна. Гэхдээ АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан зэрэг хүчин зүйлс Монгол Улсын эдийн засагт давхар нөлөө үзүүлж буй аж.

## “Ремикон”-ийн борлуулалтын орлого өсжээ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Ремикон” компанийн борлуулалтын орлого 2018 онд 17.8 хувиар өсөж, 9.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тус компани 2018 онд борлуулалтаа 20 орчим хувиар өсгөхөөр төлөвлөж буйгаа өмнө

нь мэдээлж байсан. “Ремикон”-ийн борлуулалт өссөнөөр тус компанийн алдагдал буурч, 428 сая төгрөг болсон байна. Тус компани 2017 онд 1.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байжээ. Барилгын салбарт мөнгөн

урсгалын хангамж тулгамдаж буйг тус компанийн гүйцэтгэх захирал мэдээлж байв. Монголын хөрөнгийн биржид лхагва гарагийн байдлаар “Ремикон” компанийн хувьцааны ханш 2.6 хувиар унаж, 29.2 төгрөг болжээ.

### ЗГМ ТОВЧХОН

» **ТАТВАР**

47.6

Тэрбум төгрөг. Татварын нийт орлого 2019 оны нэгдүгээр сард 626.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 157.7 тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд төлбөр хураамжийн орлого 47.6, НӨАТ 42, онцгой албан татвар 26.9 тэрбумаар өссөн нь нөлөөлжээ.

» **ТӨСӨВ**

73.8

Хувь. Улсын нэгдсэн төсвийн орлогын 73.8 хувийг татварын орлого бүрдүүлжээ. Харин 7.6 хувийг татварын бус орлого, 18.6 хувийг ирээдүйн өв сангийн орлого эзэлж байна.

» **ГАДААД ХУДАЛДАА**

94.2

Хувь. Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйл нийт экспортын 94.2 хувийг эзэлж байна. Харин импортын 73.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүн бүрдүүлжээ.

» **ДОТООД ХУДАЛДАА**

33.9

Мянга. Улсын хэмжээнд 2018 онд 33.9 мянган аж ахуйн нэгж бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.

» **НОГДОЛ АШИГ**

10

Мянган төгрөг. Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Жуулчин Дюти Фри” компани нэгж хувьцаандаа 10 мянган төгрөгийн ногдол ашиг олгохоор болжээ. Тус компани нийт 653.6 сая төгрөгийн ногдол ашигт хуваарилна.

» **УУЛ УУРХАЙ**

17.5

Сая ам.доллар. Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Sandstorm Gold компанийн орлого жилийн өмнөхөөс 12 хувиар өсөж, 2018 оны дөрөвдүгээр улиралд 17.5 сая ам.доллар болсон байна. Цэвэр ашиг нь жилийн өмнөхөөс хоёр сая ам.доллараар нэмэгдэж, 2.7 саяд хүрчээ.

» **АЖ ҮЙЛДВЭР**

10.1




Хувь. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2019 оны нэгдүгээр сард өмнөх сараас 10.1 хувиар өслөө.

### ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,629.63
Евро	3,006.13
Японы иен	24.06
ОХУ-ын рубль	39.78
БНХАУ-ын юань	391.79
БНСУ-ын вон	2.35



# Эдийн засаг



## БАЙР СУУРЬ

### ВАЛЮТЫН НӨӨЦ НЭМЭГДСЭН Ч ЭДИЙН ЗАСАГТ ЭРСДЭЛ БАЙНА

#### С.Буяндэлгэр (Эдийн засагч)

-Монгол Улсын хувьд 2018 он экспортын өсөлт өндөр, төлбөрийн тэнцэл эерэг тал руугаа эргэсэн жил байсан. Үүнтэй холбоотойгоор Азийн хөгжлийн банк 2018, 2019 оны эдийн засгийн төлөвийг өмнө нь дүгнэж байсан төсөөллүүдээ шинэчилж, 2019 оныхыг 1.4 нэгжээр өсгөсөн. Тэгэхээр АХБ 2019 онд илүү их өсөлт гарна гэж үзэж байгаа юм билээ. Гадаад валютын нөөц 2018 оны эхэн үед гурван тэрбум ам.долларт хүрч байсан бол, оны эцсийн гүйцэтгэлээрээ 3.4 тэрбум ам.долларт хүрсэн.

Гэхдээ валютын нөөц ийм байгаа ч Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр бодлогын хүүг нэг нэгж хувиар өсгөсөн. Төв банк бодлогын хүүгээ 2017 оны туршид буулгасан. Гэвч 2018 оны сүүлээс эхлээд бодлогын хүүгээ өсгөж эхэллээ. Энэ нь Монголбанк төгрөгийн ханшийг сулруулахгүйн тулд бодлогын хүүгээ өсгөж байна гэсэн үг. Манай улсын валютын нөөц өндөр, төлбөрийн тэнцэл эерэг гарч байгаа ч манай эдийн засаг тийм ч хангалттай сайн төлөвт шилжээгүйг илэрхийлж байгаа юм. Дунд хугацаанд бодлогын шийдвэр гаргаж, эдийн засагт засвар, тохиргоо хийх хугацааг ч хангалттай үр ашигтай ашиглаж чадсангүй гэж дүгнэж болохоор байна.

# 2019 оны эдийн засгийн гол эрсдэл: валютын ханш

## Алтны тушаалт хумигдахаар байгаа нь валютын ханшид эрсдэл дагуулж мэдэхээр байна

Б.Баяртогтох  
@bayartogtokhZGM

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд ногдол ашиг тараах болсноо дор бүрнээ энэ долоо хоногт мэдэгдэж, урьд өмнө байгаагүй хамгийн олон компани 2018 оны цэвэр ашгаасаа хувьцаа эзэмшигчээ баярлуулахаар шийджээ. 2017 онтой харьцуулахад компаниуд өнгөрсөн онд багагүй ашигтай ажиллаж, бизнесийн үйл ажиллагаа нь эргэн сэргэсэн гэдгийг энэхүү үйл явдал нэг талаар гэрчилнэ. Хэдий тийм боловч макро эдийн засгийн орчин бүхэлдээ сайжирсан юм алга. Төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр байна. Бизнесийн орчныг авч үзвэл, нөхцөл байдал дээрдсэн гэхээр зүйл ядмагхан. Дэлхийн банкны судалгаанаас харахад, манай улсын бизнесийн орчин өнгөрсөн онд 12 байраар ухарчээ. Үндэсний статистикийн хорооноос сар тутам гаргадаг нийгэм, эдийн засгийн ээлжит тайлангаас 2018 оны дүр зураг тодхон харагдах аж. Өнгөрсөн онд манай улсын ДНБ 6.8 хувиар өсөж, Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны таамагас дээгүүр үзүүлэлттэй гарсан. Өсөлтийн суурь нь уул уурхайн салбар

болсон. Тухайлбал, нүүрсний экспорт болон үнэ нэмэгдсэн нь эдийн засагт эерэг өсөлт авчирсан байна. Тэгвэл энэ оны эдийн засгийн төлөв байдлыг Засгийн газар мөн л нааштай төсөөлж, найман хувиар зурагласан билээ. Харин олон улсын санхүүгийн донор байгууллагууд манай улсын эдийн засгийн өсөлтийг үүнээс доогуур буюу 6-7 хувиар таамаглав. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зүгээс ОУВС-гийн хөтөлбөр үргэлжлэн хэрэгжиж байгаа тул өсөлтийг нэлээд өндөр таамагласнаа дурдсан юм.

2019 оны төсөв, мөнгөний бодлогын эрсдэлийг валютын ханш хэмээн эдийн засагч Ж.Дэлгэрсайхан тодорхойлсон. Гурван эдийн засагч тутмын хоёр нь валютын ханшийн өсөлтийг эрсдэлд тооцож байна. Монголбанкны зарласан албан ханшаар ам.доллар пүрэв гарагийн байдлаар 2635 төгрөгтэй тэнцлээ. Уг нь төгрөгтэй харьцах ам.долларын ханш энэ он гарснаас хойш ялимгүй суларч эхэлсэн ч манай улсын гадаад өрийн хэмжээ 23.5 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа нь өөдрөг төсөөллийг үгүйсгэх ээлжит тайлбар болж буй.

Валютын ханшийн өсөлтийг тогтворжуулахад валютын албан нөөцийн үүрэг, оролцоо хамгийн их байдаг. Хүлээлтийг валютын нөөцөөр удирдах нь бий. Гэхдээ манайх шиг гадаад өрийн дарамт ийм өндөр улсад дан ганц валютын нөөцөөр ханшийг тогтоон барих гэж оролдох өөрөө эрсдэл гэдгийг эдийн засагч Ц.Батсүх хэлж байсан удаатай. Ийм хүнд нөхцөлд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг

нэмэгдүүлж, хүлээгдэж буй мега төслүүдээ эдийн засгийн эргэлтэд оруулснаар ханшийн эрсдэлийг хаах боломжтойг тэрбээр тайлбарласан юм.

Монгол Улсад шууд орох валютын урсгалд “Оюутолгой” төслийн хоёр дахь шатны донор байгууллагыг эс тооцвол хязгаарлагдмал байна. Эдийн засагч сэргэж буйтай холбоотойгоор өнгөрсөн онд зээл олголт 24 хувиар өссөн. Импортын хэмжээ 5.9 тэрбум ам.долларт хүрч, 2017 онтой харьцуулахад 36 хувиар нэмэгджээ. Эдийн засаг тэлэхтэй зэрэгцээд валютын эрэлт өссөн байна. Эдгээр нь валютын ханш чангарахад нөлөөлсөөр.

### Бизнесийн орчин өнгөрсөн онд 12 байраар ухарчээ

ОУВС-гийн хөтөлбөр эдийн засаг эерэг байх нэг хөшүүрэг боловч уг хөтөлбөрийн хүрээнд олгохоор шийдвэрлэсэн санхүүжилтийн гүйцэтгэл 400 сая ам.доллараар дутжээ. Төв банкны зүгээс өнгөрсөн оны турш гадаад валютын дуудлага худалдаагаар нийт 1.2 тэрбум ам.долларын валютын захад нийлүүлсэн байдаг.

Төгрөгийн ханшид үзүүлэх валютын ханшийн өсөлтөөс гадна төсвийн тэлэлт мөнгөний бодлогын орон зайг энэ онд хумиж мэдэхээр байгаа. Төсвийн зарлагыг 2020 оны сонгуулийн өмнө гэдэг утгаар

түүхэнд байгаагүй өндөр дүнтэй баталсан. Үүнээс болж орлогын тасалдал үүссэн нөхцөлд төсвийн алдагдал үлэмж нэмэгдэх эрсдэл байгааг эдийн засагчид сануулсаар. Алт тушаалтыг өмнөх жилүүдтэй харьцуулахад энэ онд бас л буурах эрсдэл хүлээж байна. Өнгөрсөн онд 22 тонн алт худалдан авсан төв банк энэ онд хэчнээн тонныг авах нь эргэлзээ үүсгэжээ. Улсын гадаад валютын албан нөөцийг 2014 оноос зузаатгаж эхэлсэн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 2.5 хувь бус хуучнаар нь буюу таван хувиар энэ оноос мөрдөхөөр болсон. Үүнийг төв банкны алт тушаалт эрс буурахад нөлөөлнө гэж эдийн засагч Ч.Отгочулуу үзэж байна.

“Эрдэнэс Тавантолгой” компани 800 гаруй тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, үүнийхээ 10 орчим хувийг ногдол ашиг болгон иргэдэд тараахаа урьдчилсан байдлаар зарласан. Монгол Улсын экспортын 40 хувийг дангаар бүрдүүлж буй нүүрс өмнөд хөршийн зах зээлд эрэлттэй, үнэ өндөр хэвээр байна. Эдийн засагт 2018 онтой харьцуулахад илүү өсөлт гарах боломж, нөхцөл бүрдэж байгааг нүүрсний экспорт болон Хятадын зах зээлтэй холбон эдийн засагч Л.Наранбаатар тэмдэглэсэн юм. Хэрэв төсөвт төсөөлснөөр нүүрсний экспортыг 42 сая тоннд хүргэж чадвал эдийн засаг 2018 оны амжилтаа хадгалах боломж байна. Гэхдээ тоон үзүүлэлтээс гадна “Эрдэнэс Тавантолгой” компани нэг тонн нүүрсээ 70 бус 100 ам.доллараар экспортолж чадвал энэ нь эдийн засаг тогтвортой нэг хөшүүрэг аж. [ЗГМ]

### МӨНГӨНИЙ ХАТУУ БОДЛОГО БАРЬСАН ЖИЛ БОЛНО

#### Г.Батзориг (Эдийн засагч)

-Олон улсын байгууллагууд манай улсын эдийн засгийн өсөлтийг 5-7 хувьтай байхаар харж байгаа. Бодлогын хувьд сангийн тэлэх, мөнгөний хумих бодлого давамгайлсан жил болно гэж үзсэн. Сангийн тэлэх бодлогын хувьд сонгуулийн өмнөх жилд угаасаа л өсдөг. Ийм өссөн нөхцөл байдалтай холбоотойгоор инфляц дээр дарамт ирж байгаа учраас төв банкны зүгээс мөнгөний хатуу бодлого баримтлахаас өөр сонголтгүй.

Тэгэхээр мөнгөний хатуу бодлого барьсан жил болно. Эдийн засгийн өсөлтийн хувьд худалдаа, үйлчилгээний салбарт нэлээд өсөлт хүлээгдэж байна. Ханшийн хувьд орж ирэх валютын урсгал харьцангуй тогтвортой, гарах валютын урсгал буюу манай улсын зээлийн эргэн төлөлт дээр томоохон дүн байхгүй. Тийм учраас ханш тогтвортой байна. Мөнгөний хатуу бодлого баримталж байгаа учраас инфляц ч тогтвортой байх болов уу.





### 2019 ОНЫГ ТОДОРХОЙГУЙ ЖИЛ ГЭЖ ХАРЖ БАЙНА

#### Б.Дөлгөн (Эдийн засагч)

-Эдийн засгийн өсөлт ард түмэнд хэр хүртээмжтэй байна вэ гэдэг асуудал бий. Бодит цалин авч үзвэл сүүлийн гурван жилд бараг өсөөгүй. Бага хэмжээгээр өсөж байгаа ч инфляцад идэгдээд дуусаж байна. Ард иргэдийн гар дээрээ авч байгаа мөн хэрэглээнд хэр хүрч байна вэ гэдэг асуудал болсон.

Яагаад үүнийг ярьж байна гэхээр 2019 он манай улсын хувьд нэлээд тодорхойгүй жил болно. Зэс болон томоохон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн циклийг харвал аль хэдийн хамгийн өндөр үнийн түвшинд хүрээд, одоо эргэж буух цикльдээ орсон. Энэ бууралт хэзэйн хамгийн доод цэгтээ хүрэх, хамгийн доод цэгтээ хүрэх тэр үед манай улсын ард иргэд, өрх гэрүүд бэлтгэлтэй байх хэрэгтэй. Манай өрхийн хэдэн хувь нь хэдэн төгрөгийн зээлтэй байгаа билээ. Сүүлийн хоёр жилд өрхийн зээлийн хэмжээ огцом нэмэгдсэн. Зээл авсан хүмүүсийн мэдээллийг шүүж үзвэл нийт орлогынхоо 60-70 хувийг зээлдээ төлдөг гэсэн үзүүлэлт бий. Энэ юу гэсэн үг вэ гэхээр эдийн засаг эргээд ямар нэгэн байдлаар хямрахад өрх гэрүүд бэлтгэлтэй биш байна.

## ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:



Index	Value
DOW JONES	0.24%
S&P 500	0.18%
FTSE 100	0.98%
NIKKEI 225	0.15%
TOPIX	0.0019%
SHANGHAI COMPOSITE	0.34%
HANG SENG	0.41%
KOSPI	0.49%